

Д.Гармаа

ГҮҮРИЙН НУУЦ

**Сургуулийн бага насныхан зориулсан
адал явдалт туужууд**



Д.ГАРМАА

ГҮҮРИЙН НУУЦ

Сургуулийн бага насныханд
зориулсан адал явдалт туужууд

Улаанбаатар хот
2007 он

ГАРЧИГ

Гүүрийн нууц	3
Амьд тунхаг	39

Д.Гармаа

ГҮҮРИЙН НУУЦ

Сургуулийн бага, насныханд зориулав.

Зураач Н.Хүдэрчулуун

Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа

Хянагч Ж.Гэрэлмаа

Хэвлэлийн эх бэлтгэсэн Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

ГҮҮРИЙН НУУЦ

Манайхан

- Аав загасан нүдтэй юм гээч!. . . Нэгэн удаа би санаандгүй ингэж хэлчхээд аавд бузгай зэмлүүлснээ санаж байна. Яагаад ч юм бэ, аавын том нүд яг Туулын усанд байдаг тул загасныхтай хачин адилхан санагдсан болохоор би тэсгэлгүй инээд алдсан хэрэг. Тэгсэн чинь аав уурлаж, өвөөгийн хэлдгээр нэг сайн “жавтий хүртээв”.

- Аавыгаа хэзээ, хэн тэгж хэлж байлаа... энээ тэрээ гээд л ээж чухам нэг “уншлагаа” уншиж гарлаа. Би арван нэгэн нас хүрээд, өндрөөрөө өвөөгөөс дутхааргүй том болсон учир ээжийн үглэсэн үглээгүй, буруу хэрэг хийснээ мэдээд толгойгоо унжуулан зогсож байв. Ерөөсөө би тийм зантай. Ямар нэгэн болчимгүй хэрэг хийчихсэн дороо буруугаа мэддэг хэр нь, болохгүй явдалд нэг мэдэхэд л орчихдог. Саяхан сургуулийн хашаа давж, ногооны зоорины мөсөн дээрээс гулсан тоглож байгаа жаалуудыг би харлаа. Тэгж болохгүй гэдийг мэдсээр байсан мөртлөө нэг мэдэхэд хашаа давж, өнөө хэдтэй нийлж,

сургуулийн манаачид гайгүй сайн зэмлүүлэв. Эсхүл, аймгийн төв цэцэрлэгт байдаг хамгийн өндөр улиасан дээр хэн түргэн гарахаа үзэх гэж найз нартайгаа маргахдаа “Ингэж ч болохгүй дээ” гэж бодсон мөртлөө авирч билээ. Тэр авиралт төвөгтэй атлаа, үнэхээр сайхан үйл байсныг яана.

Хүүхдүүд модны тэхий гол хүрээд айн буцаж байхад би мөчир дамжаар байж арай гэж дээр нь гарав. Чухам надаас өөр хэн ч тэгж чадаагүй болохоор онгирч хашгирснаас болж, томчууд мэдэгдэн баригдсан юм даг.

Хэрэв шаардуулсаар байж буухдаа том гишүүнд өмдөө цоо хатгуулаагүй сэн бол аав ээж мэдэхгүй



өнгөрөх байсан л даа. Ноднингийн наадмаар ээжийн авч өгсөн өмд салтаагаараа зад урагдсан учраас л ээж дор нь мэдэж, мөнөөхөн унших номоо нэг оройжин дуудсан хэрэг.

Хашааны орой дээр, ээжийн огт хэрэглэхээ байсан нэг муу эвдэрхий тавгийг тавьж байгаад хэн нь мэргэн онодгоо үзэх гэж нэг удаа айлынхаа жаалтай чулуу шидлээ. Би түүнийг ганц шидэлтээр бяц цохиод эргэж хартал ээж харин гүйхээрээ ирж явна. Би зугтаахаар ухасхийсэн боловч оройтжээ. Ээж миний гараас хэдийн шүүрч авсан байв.

- Хайран ч таваг минь! Хайран ч хүү минь! . . . гэж ээж замдаа үглэж явлаа. Таваг ч яахав, ээжид хайран л юм биз. Харин би ямар тавагтай адил бут үсэрчихсэн биш гэж жаахан гайхаад, би:

- Ээж, та тэр тавгийг ямар мэргэн оносныг харсан ч болоосой. Бүр гайхалтай гээч! Ганцхан шидээд л ... гэж хэлбэл, ээж:

- Ганзориг минь, чи бидний хамгийн дурсгалтай тавгийг хагалмаа. Энэ тавгийг өвөө чинь манайхыг айл болоход бэлэглэсэн учраас би хайртай байсан юм. Ингээд хүү минь чи, миний чамд итгэдэг итгэлийг бас хагалмаа. Одоо чамд итгэж элдэв хэрэгтэй зүйлээ ил тавьж болохгүй боллоо. Чамайг ер яалтай билээ? гэж ярив. Таваг шиг будаа болтлоо хагарч орхисон тэр “итгэл” гэгчийн тухай бодоод би үнэнээсээ айв. Нээрээ надад аав ээж хоёр итгэхийг байвал юу болох юм бэ. Аав хэлэхдээ:

- Шилжилтийн нас хэцүү нас байдаг юм даа. Заавал ч үгүй зүггүй хөдөлдөг. Ийм үед хүүхдэд үглэх бус, харин зөвөөр хүмүүжүүлэх ёстой гэдэг.

- Юуны чинь шилжилтийн нас гэж. Арван нэгэн настай нялх амьтан шилжилтийн байхдаа яахав. Чи л өөрөө ажил ажил гэсээр явж, хүүхдээ хүмүүжүүлэхгүй өдий хүрсний балаг энэ!

- Долгор чи битгий хашгир. Тэгж яривал чиний хүмүүжүүлээд байгаа юм ч алга л байна. Харин энэ хүүхдийг цэцэрлэг, сургууль л өсгөж өгсөн байх.

Цаад өрөөнд нэгэн орой аав ээж хоёр ингэж, манай 3^д, 3^ө бүлгийнхэн түүхийн хичээлээр маргаан зохиодог шиг л тэмцэлдэж байв.

Аав гүүрийн инженер. Би заримдаа аав шиг инженер болоод гол болгон дээр гүүр барьж явбал сайхнаа гэж бодно. Манайх ээжийн хэлдгээр “суудалгүй айл” байв. Учир нь нэг газар жилээс

илүү бараг болохгүй. Арайхийж ганц жил өнгөрөв үү, үгүй юу аавын эхэлсэн гүүр баригдаж дуусаад, дахиад шинэ гүүр барихаар явигана. Заримдаа сургуулиас хол газар өвөлжих болбол намайг аль тааралдсан дотуур байранд оруулж орхино. Тийм ч учраас миний хувийн хэргийн дэвтэр дээр Сүхбаатар хотын дунд сургуулийн ногоон, Баянхонгорын хөх, Хэнтийн багш нарын яагаан бэхээр дүн тавьсан нь бүгд бий.

Аав ганцхан гүүр барьдаг бус бас зам засч, тэгшилж цардана. Одоо бол Зуун мод хотод манайх чухам хар зам тавих гэж иржээ.

Ээж бага эмч. Цагаан халаад өмсөөд, эмнэлэгтээ хүн хүнтэй яриад, гүйж явахад нь би ээжийг цонхоор олж хараад манай ангийн Туяатай үнэхээр адилхан, хөөрхөн юм байна гэж бодсон.

Оройд аав орон дээрээ оймстойгоо хажуулж, өдрийн сонин гарчиглана. Үдшид ширээний чийдэн асаан гүүрийн зураг хийж, бичиж тэмдэглэнэ. Намайг харах бүрдээ өрөөсөн нүдийг анивчлан цаашлуулна.

Ээж үдэш хоол хийж, дараа нь зурагтын дууг чагнахгүй гэж толгой дээрээ өдөн дэр тавиад буруу харж унтана. Угаасаа бид гурвуулаа.

Харин энэ өвөл өвөө ирэв. Өвөө маань туранхайдуу, янхигар том биетэй, эрүүндээ ооч сахалтай, монгол дээлнээс өөр хувиас өмсдөггүй билээ. Анх өвөөг нэг их том модон хайрцагтай ирэхэд би түүн дотор нь тэр өдөр бялууртлаа идсэн чихэртэй ааруул бий гэж бодсон нь эндүүрчээ. Түүний дотор харуул, цүүц, алх, өрөм, өөр юу ч билээ дээ мужаан хүний бүхий л багаж дүүрэн байв.

Өвөө маань ердөө ч зүгээр суухгүй. Ажилтай юм шиг өглөө эрт босчхоод цай чанаж, аавынх

шиг монхор хамраа хөлөртөл ууж, ногоон дүнс татаж байснаа түлээ хагалахаар гарна. Дараа нь хог шүүрдэж, энд тэнд засч тэгшилмээр юм байна уу гэсэн шиг харна.



Манайх нийтийн байрны хоёрдугаар давхарт хоёр өрөө байртай.

Өвөө, хоёр өрөөний бүх түгжээг, хаагдахыг больсон цонхны хүрээнүүдийг сольж, нэг сар болов. Дараа сард нь өвөө хонгилд (манай хоёр өрөөний дундах нүх) тавиур хийж, энд тэндгүй өнхөрч явдаг бид гурвын гадуур хувцсыг өлгүүртэй болгов. Гурав дахь сард нь өвөө хаанаас ч банз мод олсон юм бэ, нийтийн байрны хашаан дотор пин барилаа. Өвөөд цай дөхүүлж өгөөд хажууд нь суух юм уу, харуул цүүцээр нь банз харуулдан тэгшлэх надад тун ч сонин байв.

Хэрэв гүүрийн зураг ид хийж, өөрийнх нь хэлдгээр “ Уран бүтээлийн онгод ” - той ажиллаж байхад харандааг нь нуух юм уу, багажнаас нь холдуулбал аав туйлын их уурлана. Гэтэл өвөө тийм биш. Харуул яаж барихыг зааж,

- Оролдоод үз, хүү минь. Ажил болгон эрдэм болдог юм. Банз харуулаад сурчихвал том болоод махныхаа пинг хүн гуйхгүй өөрөө барьчихдаг болно шүү дээ гэнэ.

Өвөө маань нэгдлийн сайн мужаан юм байж. Өвөө надад ухаангүй сайн. Би ч өвөөгөө дагаад аймгийн төвөөр алхаж явахдаа таних хүн болгонд “Би ийм мундаг өвөөтэй!” гэж гайхуулж байгаа шиг бардам санагдана. Өвөө бид хоёрын туйлын дотно болсон нь аав ээжид ч таалагдсан хэрэг.

- Ахмад хүмүүс бол залуу үе, дунд үе хоёрыг холбож өгдөг гүүр мөн! Өвөө чинь чи болоод, ээж бид хоёрыг чинь холбож өгсөн хэзээ ч нугаршгүй бат бэх суурь бүхий гүүр болов гэж аав нэг удаа сайхан хошигносон юм даг.

Хэдийгээр би энэ үгийн учрыг сайн ойлгоогүй боловч аавыг дагаж баясан инээж байлаа.

Өвөө олон үгэнд дургүй. Тамхиа удаан сорж, гаансан дотор нь хэдгэнэ орчихсон юм шиг дуугаран, алсыг харж юм бодох дуртай. Эсхүл, яах аргагүй нэг чухал юмыг бодоод эхлэхээрээ түүндээ өгөх хариуг сахал дотроосоо олох гэсэн юм шиг хэдэн



буурал сахлаа хоёр хуруугаараа имэрч сууна. Бид хоёр нэг өрөөнд унтах тул өвөөгийнхөө орой болгон цамцаа тайлчхаад нүцгэн суухыг хардаг байв. Тэгээд би өвөөгийнхөө мэнгийг нэг орой тооллоо. Жижигхэн жижигхэн бор мэнгийг долоовор хуруугаараа дарж, аман дотроо тоолж байтал гэнэт би тохойны нь тэнд тодоос тод сорви байхыг олж харлаа.

- Өвөө өвөө энэ юу вэ? гэж би саваагүйрхэн асуув.

- Сорви...

- Юуны сорви юм бэ?

Өвөө над уруу эргэж харснаа, гаансныхаа толгойгоор далаа үрж:

- За, тийм нэг явдал болсон юм даа гэв.

- Ямар явдал?

- Юу ч гэмээр юм бэ дээ. Өвөө нь... гэхлээр би үгийг нь таслан,

- Өвөө та байлдсан уу? гэж асуулаа.

Би "Тиймээ, би байлдсан" гэж хэлүүлэх сэн гэж туйлын их хүсч байв. Учир нь дайн байлдаанд орсон эрэлхэг зоригтой өвөөтэй сэн бол ангийнхаа бүх жаалаас хамгийн мундаг нь гэж тооцогдох байлаа л даа. Харин өвөө миний энэ үгийг ер тоосонгүй. Сахал дороо муухан инээмсэглэх аядаад.

- Найзуудтайгаа чиний цасаар байлдаг шиг үү? гэв.

- Үгүй, жинхэнэ байлдаан... Яг л кинонд гардаг шиг сүртэй тулалдаан... гэж намайг босоод ирэхэд өвөө гаанс тамхиа нэг гартаа барьж, дээлээ нөмрөөд доголсхийн босч, ор луугаа явахдаа:

- Үгүй...өвөө нь тэр киноны байлдаан гээчийг үзсэнгүй. Ёх унтах минь! Өнөөдөр харин ядрав байна гэлээ.

"Томчуул ядраад чамтай ярих дургүйг мэдсээр байж, олон юм битгий шалгааж бай!" гэж аавын хэлдгийг би санаж, дахин юм ярьсангүй.



Гайхамшигт баатрын эрэл

- Та нар амьдралдаа ядаж ганц удаа ч гэсэн хүмүүст тус хүргэсэн үү? Сайн бодоцгоо!



Намхан нуруутай, зузаан бөгөөд олон хүрээтэй нүдний шилтэй, манай ангийн Туяа шиг нарийхан мөртлөө духандаа, хүзүүндээ үрчлээтэй ангийн багш Тунгаа нэг өдөр ингэж хэлэв. Тунгаа багш охидуудаас өндөргүй. Тэгсэн атлаа бусад багш нарын адил өндөр өсгийтэй гутал өмсдөггүй. Том ангийн жаалууд, охидтой андуураад Тунгаа багшийг дэгээдэж унагасан гэж ярилцдаг нь үнэн байж магадгүй. Багш минь залуухан, хөөрхөн, туйлын мөрөөдөмтгий.

- Хүүхдүүд ээ, ингэж сууж байсан чинь гэв гэнэтхэн манай ангид нэг эрвээхий орж ирээд самбар дээр суулаа гэж бодъё. Тэр эрвээхий шид үзүүлж, хүний дуугаар:

- Би бол хүслийн эрвээхий. Одоо би хүүхэд болгоны алган дээр очиж сууна. Тэгэхэд хүүхдүүд хүссэн болгоноо хэлэг! гэвэл та нар яах вэ? Мажиг чи тэгвэл хүслийн эрвээхийгээс юу гуйх вэ? гэж багш захын ширээний Мажигийг босгон асуув. Мажиг босоод толгой дээр нь эрвээхий сууж загатнуулсан юм шиг толгойгоо зөөлхөн илээд, амандаа бувтнав.

- Зүйтэй, Мажиг пуужин гуйх юм байна. Мэдээж тэр пуужингаар од гаригт л нисэх гэсэн хэрэг гэж багш хэлэв. Багш тийм зантай. Хүүхдийн хэлэх гэснийг мэдчихээд нөхөн хэлэх бол багшийн дуртай зан байв.

Мажиг бол ямагт юунаас ч юм бэ, дальдарч явдаг, толгойноосоо гараа салгадаггүй арван нэг орчим насны хүү юм. Тэр маань ангигдаа адтай зодоонч нэртэй боловч томчуулыг хармагц гөлсхийн толгойгоо илдэг хачин зантай билээ.

Дараа нь Туяа бослоо. Ангийн хамгийн хөөрхөн нь, бас онц сурлагатан. Уран сайханд явж томчуултай хамт аймгийн соёлын ордонд сургууль хийдэг. Сундуй гэдэг жаал нэгэн удаа надад хэлэхдээ:

- Туяагийн хөөрхөн нь худлаа. Гоё царайтай охидууд жаахан өсмөгц царай муутай болчихдог юм гэлээ.

- Яагаад? гэсэн чинь,

- Чам шиг нусгай нь томчуулын нууцыг мэдэх болоогүй хэмээн хамар луу няслаад, сумын наадамд хэд давчихсан бөх шиг сэтгэл хангалуун холдож билээ.

Би тэр үгэнд нь итгэсэнгүй. Манай ангийн эрэгтэй жаалуудаас яагаад ч юм би, Туяаг өмөөрмөөр санагддаг билээ. Түүний хөөрхөн царай нь нэг удаа аавын хэлсэн “Гоо сайхан бүсгүйчүүлийг алт мэт хайрлах ёстой” гэсэн үгийг надад ямагт сануулж байлаа.

Надтай чацуу тэр охин олон үггүй, дуугайхан юм бодомтгой хүүхэд юм. Ер нь охид, хөвгүүдээс арай л нүүрмэг юм уу даа гэж би бодно. Учир нь манай ангийн гучин хоёр жаалын арван хоёр нь хүү мөртлөө хэн нь ч хүүхдийн номын баяраар нэр алдартай зохиолчийн хаягаар захиа бичиж, хариу аваагүй байхад Туяа л ганцаараа захидлаар харилцдаг байв. Тогтуухан харитай, нүдэнд дулаахан ахын дурсгал бичсэн сайхан хүрэн зураг Туяагийн номын завсар байхыг би нэг удаа харж билээ.

- Энэ чинь хүүдийн зохиолч Товуу байхгүй юу гэж багш тэр зургийг ангийханд өргөн харуулж,

- Одоохондоо Туяа тэр зохиолч ахтай захидлаар харилцаж л байг. Удахгүй бид ангиараа нийлж захиа бичигчээр гэж билээ.

Ийнхүү Туяа бослоо. Тэр “Миний нутаг” шүлгийг цээжээр унших гэж байгаа юм шиг хоёр гараа өмнөө авчирч бариад, алсыг ширтэн бодол болов.

- За, Туяа гэж багш шаардлаа.

- Хэрэв би хүслээ хэлбэл...

Анги чимээгүй болов. Гагцхүү салхивчны дутуу наасан цаас салхинд сэрчигнэн хийсэх л дуудлаар, тийм аниргүй нам гүм боллоо.

- Хэрэв би хүслийн эрвээхий ирвэл... Би түүнд шидэт шохой захиана. Би тэр шохойг багш тандаа өгнө. Багш маань самбар дээр олон олон шүлэг, дуу бичнэ. Бичсэн болгон нь үе үеэрээ, мөр мөрөөрөө, бадаг хэсгээрээ бидний толгойд хэзээ ч мартагдахгүйгээр бууна гэж Туяа мөрөөдөн байж хэлэв.

Би баярласандаа алга ташив. Хүүхүүд бас алга ташигтаав. Хэрэв дараагийн хүүхэд босоод ердөө л “Мөхөөлдөс гуйна” гэж гутаагаагүй сэн бол тэр өдөр лав бүгд нэг нэгэн чухал зүйлийг хүслийн эрвээхийгээс гуйх байсан даа.

Зоригт хэмээх тэр жаалыг бид шоолон инээлдэв. Зоригт бол намхан нуруутай, давхар эрүүтэй болтлоо таргалсан арван гурван насандаа баймгүй аймхай амьтан байлаа. Морь харах газар луу шөнө ганцаараа явж чаддаггүй, баруун ангид жаалуудын зодолдоход зүүн ангид ширээний доогуур хэдийн орчихсон байдаг бүр нэг аймхай амьтан сан.

Ангийн ажил явуулах өдөр Тунгаа багш ийнхүү хариулж болмооргүй асуулт бидэнд тавив. Энэ удаад харин Зоригт л хамгийн түрүүнд гараа өргөлөө.

- За хэл дээ. Багш аргаадсан юм шиг, гуйсан ч юм шиг зөөлхөн ингэж хэлэхэд Зоригт,

- Би гурван зурам агнасан! гэж хэлчхээд, мундаг байгаа биз гэсэн адил эргэж харав.

- Үухайс. Тэгээд түүнийг хэнд зориулж агнасан хэрэг вэ?

- Танд гэж Зоригт огтхон ч бодолгүй хариулахад бүх хүүхэд нирхийтэл инээлдэв.

- Байз байз, сайн бодьё. Тэгэхдээ чи гурван зурамны арьс надад тушаах нь тушаасан л даа. Би түүний чинь яалаа даа байз гэж багш бодолхийлэв.

- Та түүнийг хүүхдүүдийн авчирсан тарвага, зурамны арьс, хатаасан цэцэгтэй хамт сургуульд өгчих нь билээ гэж Зоригт хэлэв.

- Тэгвэл чи надад тус болсон хэрэг биш, харин сурагчийнхаа үүргийг биелүүлсэн юм байх нь ээ гэж багш тайлбарлав.

- Тийм гэж Зоригтыг хэлэхээр нэг охин:

- Зоригт тэгвэл өөртөө л тус болсон юм шив дээ гээд бид инээлдэв.

- Чимээгүй, хүүхдүүдээ! гээд багш,

- Би асуултаа давтъя. Хэн гэдэг хүнд тус болсноо санацгаагаач гэлээ.

- Би Должин эмээд гурван шуудай аргал түүж өгсөн.

- Би тэгвэл Даш гуайн алдсан хээр үрээг айлын адуунаас олж өгсөн.

- Би сургуулийнхаа ногооны газарт зэрлэг өвс зулгааж өгсөн гэж хүүхдүүд шаагилдлаа.

- Их сайн байна. Хүнд туслах сан гэсэн ариун сайхан хүслэн манай хүүхдүүдэд бий.

Тэгвэл одоо бүгдээрээ нэгэн чухал сайхан зүйл сэдэцгээе. Эх орныхоо төлөө тулалдаж, баатар гавьяа байгуулсан хүмүүсийн гавьяаг бид тодруулгаая. Тийм хүнийг эрэн сурвалжлах амар биш. Дайн тулалдаан болоод олон жил өнгөрчээ. Харин тэр тулалдаанд цэл залуу байсан хүмүүс одоо өвгөн буурлууд болжээ. Тэднийг олж алдрыг нь мандуулбал сайхан биш үү, хүүхдүүд ээ?

- Зүйтэй зүйтэй.

- Тэгье, багшаа. Эрэн сурвалжилъя.

- Хүүхдүүд ээ, би та нарт нэг шүлэг уншъя. Үүнийг манай ангийн Г.Туяа бичсэн юм.

“Өнөөдөр би мөрөөдөж явна

Өглөө бүр хүсч явна

Аль тааралдсан бүхнийг

Анзаарч харах бүрийдээ

Ямар учиртайг сонирхон

Ямагт гайхаж явдаг.

Харсан бүхэн нь сонирхолтой

Хавьтсан бүхэн нь хачирхалтай

Хүүхэд нас сайхан юм

Хүсэн мөрөөдөх гайхам юм”.

Багш энэ мөрүүдийг уншиж дуусахад би Туяа уруу харав. Туяа бас над уруу хараад ичсэн юм шиг тонгойлоо.

- Энэ бол үнэхээр үнэн шүлэг. Жинхэнэ яруу найраг болоогүй ч байж магадгүй. Харин Туяа болоод та нарын хүсэл мөрөөдлийг бүрнээ илэрийлж чадна. Тэгэхлээр бид цөмөөрөө мөрөөдөгчид юм. Ганцхан мөрөөдлөөр бүхнийг орлуулж болдог сон бол бидний үйлс тун ч амархан бүтэх сэн. Гэтэл амьдрал зүгээр нэг мөрөөдөөд ажил бүтдэггүй, харин түүнийг биелүүлэх хэрэгтэй гэдгийг та нар ойлгох ёстой. Бидэнд энэ дулаахан сургуулийн танхим, гэрэл цацарсан өргөө барьж, биднийгээ харийн дайснаас халуун цээжээрээ хаан тулалдаж тэмцэлдэж явсан тэр гайхамшигт баатрууд хаана байна. Түүнийг л олцгооё, хүүхдүүд ээ! гэж багш инээмсэглэн хэлэв. “Манай багш хөөрхөн ч юм уу даа” гэж би хааяа ээжийг хайрладаг шигээ энэхэн зуур өхөөрдөн бодлоо.

Гайхамшигт баатрын эрэлд бид ийнхүү гарах хүсэлтэй болсон байлаа.

Өвөө

Тийнхүү би гайхамшигт баатрын эрэлд гарав. Түүнийг аймгийн төвийн хашаа байшингуудын хаа нэгтээгээс олох гэсэн юм шиг, би юм болгоныг ажиглаж явна. Хаврын салхинд хийсч ирээд, хог цаастай хамт байшингийн нөмөрт байж байх юм шиг Зоригт тэдгээр цаасыг гутлынхаа хоншоороор тараан хаяж шалгав. Тэгсэн чинь бөхийгөөд, нэг сонингийн тасархай оллоо.

- Баатар чинь генерал хувцастай, сахалтай хүн байдаг юм уу? гэж Зоригт өнөөх цаасаа барьсаар ойртон асуув.

- Яаж байна?

- Хар л даа. Халх голын баатар гэж энэ хүний зурган дор бичсэн байгаа биз гэж Зоригт өнөөх цаасаа бидэн үрүү сарвайв. Нэг хүүхэд сонингийн тасархайг дэлгэж тавиад, "Халх голын баатар" хэмээн уншив. Нээрээ тэр сонин дээр генерал хувцастай, сахалтай, настай өвөөгийн зураг байв. Миний толгойд жинхэнэ баатар, генерал хувцастай ийм хүн л байж таарна гэсэн бодол зурсхийлээ. Би ер нь дайны баатрыг яагаад ч гудамжинд жирийн нэг алхаж байхгүй, мань мэтийн нусгайнуудтай

ярихгүй дээ гэж боддог билээ.

Аймгийн музейд, шилэн хоргоны цаана зураг нь байдаг ховор нандин тийм хүмүүсийг цонхны цаанаас харахаас биш дэргэд нь очиж ер болохгүй. Манай өвөө шиг мэнгээ тоолуулаад нүцгэн сууж байхгүй гэж би батаар боддог байв. Тэгсэн чинь манай ангийн Дооров хэлэх нь:

- Би тэр Халх голын баатар гэдгийг чинь үзсэн, мэдэв үү? Хөмсөгнийхөө тэнд мэнгэтэй юм билээ гэв.

- Хаана? гэвэл,

- Хотод. Би ахындаа очсон юм байхгүй юу. Ах намайг уулзалтанд

дагуулж очлоо. Үйлдвэр дээр нь нэг их уудам, манай сургуулийн биеийн тамирын заалнаас ч том танхим дотор олон хүн цугларсан



байв. Цэргийн даргын хувцастай, ёстой мундаг өндөр өвөөг хоёр хүн дагуулж орж ирлээ. Тэгсэн чинь халх голын баатар гэдэг нь юм байж. Дайнд орж яаж эрэлхэг байлдсанаа өвөө ярих. Би түүний хөмсөгний жижиг товруун мэнгийг харсаар байлаа.

- Ганзориг оо, тэр товрууг өвөө лав байлдаанаас олсон байх, тийм үү? Би лав тэгж бодсон гэлээ. Гайхамшигт баатар ямар байх тухай миний ойлголт ингэж баяжсаар байлаа. Манай ангийнхан өдөр болгон сураг тавивч жинхэнэ баатрыг эс олоод, харин шинж тэмдгүүдийг нь цуглуулдаг болов. Мажиг, хичээл эхлэхийн өмнө хэлсэн нь:

- Хүүхдүүд ээ, аймгийн захиргаанд цэргийн хэлтэс бий. Тэр хэлтсийн дарга бидний эрээд байгаа тэр хүнийг лав хэлнэ дээ гэхэд нь,

- За боль доо. Цэргийн хэлтэст бүртгэлтэй юм бол, тэр чинь гавьяа нь тодорсон баатар л байх сан биш үү? Бид чинь нэр нь тодроогүй баатрыг л олох гэж байгаа шүү дээ.

Нэр нь тодроогүй нуугдсаар байгаа баатрыг тодруулах хүсэл намайг нойргүй болгов. Хичээлээсээ тарж ирээд, аавыгаа ширээний чийдэн асааж, гүүрийн зураг хийж байхад би хажууд нь сэмээрхэн очлоо.

- Аав аа!

- Аа!

- Та надад туслах уу?

- Юугаар?

- Би нэр нь тодроогүй баатрыг олох ёстой. Халх гол 45 оны байлдаан, эсхүл... эсхүл өөр ямар нэг тулалдаанд оролцож гавьяа байгуулсан мөртлөө нэр нь тодроогүй тийм баатар... Та мэдэх үү? Аав гортигоор дугуй зурж, шугамаар тэнхлэг татаад хэлсэн нь:

- Нэр нь тодроогүй баатар. Чи ер нь саваагүй хүүхэд юм. Тийм хүн олдохгүй. Учир нь манай аймгийн төвд л лав байхгүй. Ерөөсөө баатрууд хаа саагүй байж байдаг эгэл хүн бус. Тэр чинь баатар шүү дээ! Баатар хүн гэгч нийгмийн захиалгаар хагас зуунд цөөхөн хэд төрнө. Тэд чинь ер бусын зоригтой учраас л ховор байгаа хэрэг. Хариулт ойлгомжтой юу? Тэгвэл явж унт. Би юм хийж байна гэлээ. Миний ойлголтыг баяжуулж өгсөн аавын эл ярианаас би "дэлхийд ховор" гэсэн үгийг амандаа шивнэсээр өвөө үрүүгээ буцлаа.

Маргааш нь миний аз таарав. Хэрэв ээж хуралтай, аав ажилтай учраас эцэг эхийн хуралд өвөө очих болоогүй сэн бол тийм аз надад яагаад ч тохиолдохгүй байсан нь мэдээж. Би далан долоон мэнгэ, нэг сорвитой өвөөгөөрөө бахархдаг байв. Нэгдэлд тэргүүний мужаан нэртэй явсан өвөөгөө би хэнд ч магтах, гайхуулахад бэлэн байлаа. Тэгсэн чинь өвөө сургуулийн босго алхав уу, үгүй юу танилтайгаа учирдаг байна. Манай өвөө сургуулийн үүдэнд дежур өвөөг хармагцаа таниж,

- Үгүй хөөе, Дорлиг! Хараач гэм! гэж дуу алдах нь тэр. Жижүүр өвөө ч бас “Энэ чинь одоо хэн бэ дээ” гэсэн адил урдаас нь харж харж,

- Дамдин! Ямар сонин учрал бэ! гээд босов.

- Олон ч жил уулзсангүй. Алив хө, золгочихьё доо! гэж манай өвөө хоёр гараа тослоо.

- За, энэ чинь хаанаас гараад ирэх нь энэ вэ?

- Ач хүүгийнхээ ангийн хуралд ирж байна. Баянхонгороос намар ирсэн. Энд манай хүүгийнх байдаг юм. Зам гүүрийн инженер. Ганц бие өвгөн, хүүхдүүдээ бараадаж яваа юм даа...

- Тэгэлгүй яахав, хөөрхий! гээд жижүүр өвөө хөөргөө өгөв. Хоёр өвөө хөөргөө солилцож, аан уун гэж дуу алдацгааж байхад би анги уруугаа явлаа. Үнэндээ би баяртай байлаа. Өвөө минь энд ирээд таних хүнгүй уйддаг байсан л даа, зайлуул. Одоо танилаа олсон болохоор лав уйдахгүй. Гаансныхаа толгойд хэдгэнэ хийчихсэн шиг хачин дуу гарган тамхиа сорж, алс уруу харан юм бодон бодон суухгүй. Өвөө маань Тунгаа багшид туйлын их таалагдав.

- Танай өвөө чинь хөөрхөн өвөө байна. Лав их үлгэр мэддэг байх, тийм үү? гэж Тунгаа багш надад хэллээ. Хоёрдугаар улирлын шалгалт дөхсөн байв. Тунгаа багш хүүхдүүдийн урьдчилж гарсан дүнг хэлж, юун дээр анхаарахыг захиад,

- Манай ангийнхан нэг чухал ажил сэдэж байгаа. Эх эцгүүд ч гэсэн тэр ажилд туслах байх гэж итгэж байна. Энэ бол нэр нь тодроогүй баатруудыг тодруулах ажил юм. Үнэхээр эрэлхэг тулалдаанд орж явсан хүн байвал та нар бидэнд хэлж өгвөл сайн сан. Хэрэв мэдэхгүй байвал сураг ажиг гаргаж өгсөн ч болно гэлээ.

Би математикийн хичээл дээр дундтай байснаа саяхан

засуулсан болохоор өвөөгийн өмнө нүүр бардам байлаа. Тэгээд ч Тунгаа багш “Хөөрхөн өвөө” гэсэн тул өвөөгөөрөө би бахархаж суув. Эх эгийн хурлаас буцах замдаа өвөө, нэр нь тодроогүй баатрыг олох даалгавар чухамдаа надтай адилхан багшаас авсан юм шиг,

- Одоо хоёулаа яаж баатрыг олно? гэж асуулаа.

- Бид зөндөө эрсэн боловч олдохгүй байгаа юм гээд би хэрхэн аав, “Жинхэнэ зоригтой баатар, нийгмийн захиалгаар цөөн төрдөг. Одоо бол тун ховордсон” гэж хэлсэн тухай яриу.

- За тэр ч арай юу л бол. Юу ч гэсэн хоёулаа эрнэ гэж өвөө хэлэв.

Өвөө нэг сонин юм бодож олсон байхаа ч ядахгүй. Ер нь өвөө аавын албархуу, ээжийн үглээ хоёроос огт өөр хүн. Өвөө тэгээд багшийн хэлсэнд баярлан догдолж, одоо бол сураггүй байгаа, хаа ч яваа нь үл мэдэгдэх тэр гайхамшигт баатрыг олох гэж бодон мөрөөдөж явна. Маргааш нь намайг сургуулиас ирэхэд өвөө туйлын баяртай уулзав.

- Нааш ир гэж өвөө нууцлаг байдалтай намайг өрөө үрүүгээ дуудлаа. Хойноос нь дагаж ороход өвөө хэлэв:

- За, жижүүр өвгөн Дорлиг байна шүү дээ. Тэр их сүрхий хүн. Урт чихтэй, хэзээний тийм зантай сан. Биднийг юм дуулаагүй байхад Дорлиг л аль хэдийн дуулчихсан байдаг. Өнөөдөр би түүнтэй уулзаж, юу дуулж мэдсэний нь асуулаа. Халх голын байлдаанд орсон хэдэн хүн байдаг гэнэ. Би тийм нэгэн түүхийг чамд хуучилъя, тэгэх үү?

- Яриач өвөө, яриач! гэж л би шаардлаа.

- Чи сэтгэлдээ дүрслэн бодоод үз. Манайхан японы эсрэг давшиж байлаа... гэж өвөө гаанс тамхи, хэдэн шагай, миний харандаануудыг ширдэг дээр тараан хаяв.

- Аа, энд дайсан байна гээд өвөө нөгөө талд нь гудамжнаас авчирсан хэсэг чулуу асгав.

- Энэ хоёрын дунд гүүр байна. Цорын ганц гүүр. Тэр гүүрийг дайсан эзэлжээ. Хэрэв гүүрийг л манайхан авлаа бол монголын морин цэрэг нөгөө тал уруу гарч дайсныг хиар цохих юм. Гол үертэй учраас мориор гарахад аюултай байна. Бүр сүүлд, дайны дундуур зөвлөлтийн цэргүүд хөвдөг гүүр олныг тавьсан л даа. Түүнээс өмнө болсон хэрэг. Манайхан давшиж, дайсныг зөвхөн

Халх голын цаад талд хорих хэрэгтэй байлаа. Тэгэхлээр яах билээ?

- Гүүрийг эзэлнэ! гэж би хэлэв.

- Зөв. Гүүрийг эзлэх хэрэгтэй. Харин яаж? Бөөнөөрөө дайрч очвол гүүрэн дээр дайсны пулемёт бий. Тэр шүршиж орхино. Их буугаар буудья гэхлээр гүүрийг эвдэж болзошгүй.

- Сэмээрхэн гэтэж очоод, харанхуй шөнө гүүрийг эзлээд авчихгүй юу! гэж би өөрөө л тэр лүү одоохон явах гэж байгаа юм шиг өндөлзөв.

- Зөв. За тэгэхлээр, эрэлхэг дарга нь таван цэргээ дуудаад үүрэг өгсөн байжээ. "Та нар шөнийн харанхуйд гүүр лүү очин, ямар ч аргаар хамаагүй эзэлж ав. Харин гүүр бүтэн байх ёстой. Гүүрээр өглөө эрт морин цэрэг давших дохиог улаан пуужингаар өг" гэж дарга нь тушаажээ. Чухам яаж тэд гүүрийг эзэлсэн болоод яаж морин цэрэг түүгээр гарч дайсантай тулалдсан тухайг нь хэн ч мэдэх юм алга. Харин тэр тав гүүрийг эзлээгүй бол морин цэрэг түүгээр гарч, ялалт тийм түргэн ирэхгүй байсныг л хүмүүс мэдэж байна. Тэд чинь айхтар баатрууд биш. Ерийн л таван цэрэг. Юу ч гэсэн цэрэг хүнийхээ үүргийг л тэд биелүүлсэн хэрэг. Ийм хүмүүс танай ангийнхны эрээд байгаа хүмүүс мөн үү?

Өвөөгийн царай, нүдний харц надаар "Мөн, яг тийм хүмүүсийг бид эрж байгаа юм!" гэж хэлүүлэх гэсэн байртай байсан боловч, би чухам энэ явдлыг баатарлаг гэх эсэхийг сайн мэдээгүй байсан тул.

- Би багшаас асууя, өвөө гэж хэлэв.

Тэр гүүрэн дээр ерийн нэг дайсан байгаагүй пулемёт буутай, том хүч байсан нь тодорхой болохоор тийм дайсны эсрэг зориглон очиж гүүрийгчөлөөлсөн таван цэрэг бол нээрээ гайхалтай баатарлаг хүмүүс байж таарна л даа гэж би бодлоо.

Эрэл үргэлжилж байна

- Одоо хүртэл хүн өөрийнхөө нууцыг таньж мэдээгүй л яваа хэрээг.

Хүн гэгч сонин амьтан юм шүү гэж аав хэлдэг билээ. Аав түүнийг уншиж байгаа сониноосоо авсан байх гэж тэгэхэд бодсон. Учир нь аав ном уншчхаад дандаа гайхаж, дуу алдаж

байдаг.

- Долгор оо! Үгүй мөн гайхамшигтайяа! Хархираагийн оргилд олон улсын уулчид авирсан байна шүү гэнэ. Эсхүл:

- Долгор оо! Пушкин есөн настайдаа анхны шүлгээ бичсэн байна шүү дээ. Манай Ганзориг чинь хэдтэй билээ? гэж асуух жишээтэй.

Харин энэ удаад өвөө тэдний ярианд оролцов.

- Ганзориг ангийнхаа хүүхэдтэй нийлж, гавьяа байгуулсан хүмүүсийг эрж байна. Энэ лав буянтай үйл мөн. Би юу ч гэсэн хүүгийнхээ ажилд туслах юм байна. Өтөлсөн болохоос үхсэн биш дээ хө. Балбар чи ч гэсэн тусалмаар юм, Долгор ч гэсэн...

Өвөөгийн хэлсэн нь генерал цэргүүддээ тушаахын дайтай сонсогдсон хэрэг байх. Аав хэвтэж байснаа босч, ээж ч өндөсхийв.

- Дулаан сайхан байранд байна. Ямар түлээ хөрөөдөж, ус зөөнө гэх биш. Оройжин сүүжээ чилтэл хэвтэцгээх ч сайн ёр биш дэг. Ганц хүүтэй гэж байгаа. Дэмжиж туслахыг ч бодохгүй. Малчин хүн түлээ хагалж оруулж, мөс ус зөөж, хонь малаа хотлуулах гэсээр байтал шөнө дөл болдог. Тэгж ажил хийж хөдлөв гээд муу юм болсонгүй. Дэмий хэвтсэнд орвол амьтан хүнтэй уулзаж, хүүдээ тэр эрээд байгаа хүнийх нь сургийг гаргадаг болоосой.

- Хэнийг эрээ вэ? гэж ээж сэтгэл нь зовсон юм шиг надаас асуув.

- Баатар үйлстнийг...

“Энэ ажил лав сонин байх” гэсэн адил аавын нүдний хари сониучирхсан өнгөтэй боллоо.


- Би эрээд, олоод өгөх үү? гэж ээж, айлынхаа эмээгээс “хуучин торгоны өөдөс авдрандаа үзээч” гэж хэлдэг шигээ асуулаа.

- Би ч нэг хүний сургийг гаргаад байна л даа, зүгээр... Жинхэнэ баатар мөн үү, биш үү гэж өвөө гаансаараа нуруугаа маажин хэллээ.

“Одоо хүртэл хүний нууц тайлагдаагүй” гэсэн аавын үг ямар үнэн болохыг би сая л мэдэв. Аав ээж хоёр маань гавьяат үйлстнийг эрэх үнэхээр сонирхолтой, зохиолч нарын хэлдгээр бүр онгодтой хөөцөллөж чадах сэтгэлийн их нөөцтэй хүмүүс болохоо удахгүй надад харуулав.

Ажил тармагц аав хэвтэж сонин гарчигладгаа ч больж, ээж жинтүүгээр чихээ даран унтдагаа ч байв. Аав өдөржин ийш тийш утасдаж, ээж үеийн хүүхнүүдээ хоёр гурваар нь дагуулж ирнэ. Тэр хүүхнүүд нь нарийхан янжуур хуруундаа хавчуулан тамхи баагиуцгааж, цүнхээ уудлан гэрэл зураг гаргаж ширээн дээр дэлгэцгээнэ. Тэр зургийн тайлбарыг ард нь бичсэн байв. Эхлээд өөрсдөө баахан үзэж, дараа нь өвөө бид хоёрт шилжүүлэнэ. Би өвөөд тайлбарыг нь уншиж өгдөг боллоо. Нэг зурагны ард “Түймэр даралцахад оролцсон” гэж бичсэн бол нөгөөгийнх нь ард “Хоршооны манаачаар хорин гурван жил ажилласан”, эсхүл “Шоронгийн оргодлыг барилцсан”, “Цэрэгт модон морин дээр харайсан нь” гэх мэт инээд хүрмээр юм ч бичсэн байв. Хамгийн инээдтэй нь ээж болоод үерхдэг авгай нар нь манай ангийн охидууд дүн сонсох гэж яаж догдлон хүлээдэг шиг л нүд нь гялалзан хариу хүлээцгээнэ. Өвөө зураг болгоны тайлбарыг надаар уншуулаад,

- Зөв дөө, хүүхэд минь, зөв. Үнэхээр гавьяа байгуулсан хүмүүс юм хөөрхий. Харин Ганзориг өөр хүмүүс хайж байгаа л даа. Томоохон байлдаанд оролцсон ч юм уу, ухаан нь Халх гол, эсхүл баруун хязгаарт тулалдсан ч юм уу, тийм хүн л олдвол сайн сан гэнэ. Олж ирсэн зургуудыг нь өвөө бид хоёр голоогүй болохоор ээж нарын сэтгэл амарч тун ч баяртай инээмсэглэцгээнэ. Тэгээд:



- Бид заавал олно гэж амлацгаагаад гарна. Сургий нь өвөө гаргасан хүн нь аймгаас холгүйхэн нутагладаг нэгдлийн гишүүн Дэндэв гэдэг малчин байв. Тэднийд очихоор нэг өдөр аав бид нар явав. Өвөө тэр өдөр өөр хүний бүдэг бадаг сураг гаргасан тул учрыг мэдэхээр үлдлээ. Харин манай ангиас Туяа явалцав. Олон хүүхэд явья гэж гуйсан боловч Тунгаа багш, Туяаг л төлөөлөгчөөр нь явуулаа. Алив нэг шинэ ажил эхлэх сонин байдаг бололтой. Манай ангийн хүүхдүүд цөмөөрөө л эрэн сурвалжлахын онгодоод автсан байлаа. Бусад айлууд ямар байсныг би мэдсэнгүй. Харин манай гэрийнхэн тэр чигээрээ ангийнхны минь хүсч сонирхож байгаа эрэлд гарсан байлаа. Хүүхэд болгон өдөр бүр ямар нэг сонин намтартай хүмүүсийн тухай дуулж ирнэ.

Өглөөний шуугиант мөчид манай 3^д-ийн хөвгүүд хуучин шигээ ном дэвтрээрээ шидэлцэх юм уу, түр зуурхан шөргөлцөөд авах, охидууд гээг үсээ зулгаалцан, айсан муур шиг дуугаригаахыг байв. Их үйл хэрэг бидний саваагүй занг холдуулсан хэрэг юм болов уу, өглөө хичээл эхлэхийн өмнө түр зуурын заванд цөмөөрөө цуглаад хэн гэдэг ямар хүний сургийг гаргаснаа ярилцаад авна. Би тэдэнд ээжийн найз нарын авчирсан зургийг үзүүлнэ. Хүүхдүүд инээх нь инээж, юм бодох нь бодож, зарим нь зураг хүртэл зурна гээч. Их үйл явдал бас бидний урмыг сэргээж, долоон жигүүрийн аяны маань эрч хүчийг нэмж, сурлагыг ахиулав. Ийнхүү бид туйлын цовоо сэргэлэн, ажилсаг хүүхдүүд боллоо. Харин Зоригт л тийм бус. Зоригт бидний халуун ярианд тэр болгон оролцохгүй. Ерөөсөө Зоригт алив үйл явдлыг холоос ажиглах дуртай, тэр л зангаараа дуугүй суун ажиглаж байв. Зоригт бусад хүүхдүүдтэй адилхан баатарлаг үйлстний эрэлд гарах ч үгүй, ер бүр үйл явдал өөрөөс нь холуур өнгөрвөл болов гэсэн мэт хөндлөнгөөс ажигласаар байлаа.

За тэр ч яах вэ, бид Дэндэв гуайн гадаа хүрээд ирлээ. Дэндэв гэдэг маань таягтай, туранхайвтар, өвгөжөөр хүн байлаа. Өвөлжөөндөө өдөрт авч үлддэг хэдэн төлөг борлонд өвс тавьж өгч байх үед нь бид тааралдав.

- Бид тантай уулзах гэж ирлээ гэж аав хэлэв.

- Юу болоо вэ?

- Юу ч болоогүй. Зүгээр л сургуулийн 3^д ангийн хүүхдүүд... Өөрөөр хэлбэл гавьяат үйлстнийг эрэн сурвалжлах бүлгийн

гишүүд... Би бол ерийн нэг аав. Эдэнд тусалж яваа ухаантай юм байхгүй юу.

- Гэрт оригоо гэж тэр хэлээд тэвэрч байсан өвсөө тарааж хаячхаад түрүүлж алхав.

- Таныг Халх голд байлдсан гэж дуулаа. Яаж байлдсанаа энэ хүүхдүүдэд яривал сайн байна гэж аав гэрт орсон хойноо хэлэв.

- Хээ цэс! Миний байлдах ч дээ гэж өвөө хэлээд хойморт сөхрөн сууж,

- Хөгшин, чи цай чана. Бас хоол хий. Миний өнөөх медаль хаана билээ? гэв.

- Өөрөө л эртүүд гаргаж ирээд зүлгэж зүлгэж, бааданд боох тань билээ гэж хөгшин эмээ хариу хэлээд тогооныхоо халбийг авлаа. Өвөө мөлхөөгөөрөө авдар луугаа дөхлөө. Би хүртэл "Ховордсон амьтан"-ыг хараад аавын хэлсэнтэй зүйрлэн бодож, ер баатар эрийн шинжгүй, хатингар туранхай өвөө байхад нь гайхасхийв. Өвөө хоёр баадан уудалж үзээд, гуравдахийг задалж байснаа инээж,

- Тэгнэ ээ тэр. Буруу эрэлд хатлаа гэдгийг мэдээд байсан юм. Энэ авдранд биш нөгөө авдранд нь бий л дээ, нээрэн гэж хэлээд буруу тал уруу мөлхөв.

- Та мэдээж одон медальтай. Түүнийг бид үзсэн үзээгүй мэднэ. Эрж төвөг удаад яахав. Харин та яаж байлдсанаа л яривал болоо юм биш үү гэж аав хэлэв.

- Үгүй, би медалиа одоохон олоод орхиё. Дараа нь ярьж болно гээд өвөө баруун авдрынхаа тагийг авлаа. Удсан ч үгүй хадганд боож хөвөнд ороосон нэгэн нандин юм гаргаж ирэв. Тэгээд олон давхар боолты нь задалж медалийг гаргав. Өвөөгийн алган дээр "Халх голын дөчин жилийн ой" гэсэн алтлаг шар өнгөтэй медаль цоо шинээрээ гялалзаж байлаа.

- Та тэгээд чухам яаж байлдсан юм бэ?

Аавын энэ асуултанд яаж хариулья даа гэсэн мэт өвөө хөөргөө гарган үнэрлээд ярьсан нь:

- Би бол гавьяа байгуулсан нь бус. Бидний таван цэргийг гүүр эзэл гэж явуулсан юм байхгүй юу. За байз, хэн хэн байлаа даа. Аа тийм. Дорлиг гэж нэг гайхал байсан. Моринд их сайн, алиа золиг юмсан. Нөгөө гурав нь... нэг өндөр цэрэг... Нэр нь хэн билээ дээ, мартжээ. Бас нэг барилддаг гайхал... Гуравдах



← *2006.*

нь... бас л нэр нь алга. Үджээ.
Хүүхэд минь удаж. Дөчин жил
өнгөрч шүү дээ.

- Яах вэ, өвөө, яахав. Та зүгээр яаж
гүүрэнд ойртсоноо л...

- Хүн болгон үүрэгтэй явсан юм.

Таван цэргийн нэг нь ахлагч байлаа.

Өнөөх барилддаг гайхал дарга нь. Шөнө

юм даг. Бид нар гүүр лүү мөлхлөө. Намайг эхний

манаач уруу явуулаа. Хэрэв түүнийг чимээгүй

болгож гэм, цаашаа ойртож болох байв. Би мөлхөөд л

байлаа. Тас харанхуй шөнө. Гол үертэй байсан цаг юм даг.

Газар нойтон, бороо ороод удаагүй болохоор өвдөг нороод

хорсох шиг болж байлаа. Тэгээд яахав дээ, манааны хажууд

тулж очоод амьсгалаа хураан чагналаа. Гүүрний эхний манаач

гүүрнээсээ арваад алхам зайтай, буугаа бэлхэн бариад сэргийлж

явна. Би ахиад хэдэн алхам дөхөв. Дуу чимээгүй дарж авах хатуу

үүрэгтэй байсан юм. Хэрэв л манаач буу дуугаргавал гүүрэн

дээрээс пулемёт тачигнаж, хамаг амьтан бидэн үрүү дайрна шүү

дээ. Би амьсгаа даран хүлээсээр байлаа. Тэгээд би ухасхийв... Би

үүргээ биелүүлсэн юм хүүхэд минь. Намайг харин мартсангүй.

Түүний төлөө би энэ медалийг хүртсэн юм санжээ.

- Өвөө, та бусад нөхдөө одоо хаана байгааг мэдэх үү? гэж
аав "Үгүй" гэж хэлэх вий дээ гэж айсан мэт болгоомжтой асуув.

- Манай энэ хавьд гурав нь л лав бий юм даг. За байз, хэн хэн

сэн билээ? Өвөө бодоод бодоод олсонгүй. Бид буцаж явав. Дайны

баатар энгэр дүүрэн одонтой, генерал хувцастай биерхүү том

хүн байх ёстой гэсэн миний ойлголт зөрж эхлэв. Тийм хүн хаана

ч байж болзошгүй. Ямар ч ажил хийдэг байж магадгүй гэсэн өөр

нэг санаа миний санаанд бууж ирэв. Туяа замдаа хэлсэн нь:

- Эмэгтэй хүн дайны баатар байж болох уу?

- Бололгүй яах вэ. Түвдэнгийн Борыг сана л даа гэж би
хэлэв.

- Тэгвэл манай Тунгаа багшийн ээж Халх голын байлдаанд

оролцсон гэж хүн ярьж байна билээ. Харин буу барьж байлдаагүй

байх л даа. Эмнэлэгт сувилагчаар л явсан байх гэж Туяа хэлэв.

- Зөв шүү. Бас нэг хүний сураг гарах нь тэр. Хэрэв тэр эмээ

Халх голд явсан нь үнэн бол гүүр эзлэхээр тулалдсан таван цэргийн тухай лавтай мэдэж байх ёстой гэж аав хэлэв.

Хүмүүс ойртож байна

Нэгэн зорилго хүмүүсийг ойртуулдаг. Аавдандаа ингэж хэлдэг билээ. Манай гэрийнхэн дайны баатрыг хайх нэгэн зорилгод нэгдэн нийлжээв. Ерөөсөө манай гэрт өөр ажил байхгүй юм шг, бүгдээрээ л баатрын эрэлд гариггаж, түүнийхээ тухай ярьгагах болов.

Энэ нэгэн зорилго бас манай ангийхныг ойртуулав. Ялангуяа урьд өмнө ялимгүй хөндий байсан Туяа бид хоёрыг л лав ойртуулаа. Би өвөөгийнхөө тухай Туяад ярьсан болохоор тэр,

- Би очиж үзвэл болох уу? гэж нэг удаа асуулаа.

- Бололгүй яахав. Явья аа! гэж би дагуулав. Энэ бол математикийн олимпиад болсны дараахан билээ. Цагаан сар дөхөөд, хэдий хүйтэн боловч байшингийн нөмрийн цас мөс хөлрөн алдаж, эрхбиш урь амьсгал ирж байсан цаг. Гудамжинд тогтсон мөсөн дээр гулгаж тоглохын аргагүй болсон байлаа.

- Багшийн хэлдэг хүслийн эрвээхий надад байгаасай. Тэгвэл, дайны баатруудыг тэр яасан амархан олох бол оо? гэж би хэлэв.

- Хүслийн эрвээхийг гуйхгүйгээр бид өөрсдөө олохоо л олно гэж Туяа юм бодон хэллээ. "Туяа ийм л ухаантай охин" гэж би дотроо сайшаан бодлоо. Өөрт нь богинодсон эрээн пальтотой, өндөр нуруутай, туранхай, хөөрхөн энэ охин надад шаазангаар хийсэн тоглоом шиг тун ч эмзэг турьхан санагддаг билээ.

- Би цүнхий чинь барих уу? гэж энэ эмзэг амьтны гар өвдөх вий гэж айсан мэт би асуув.

- Тэг л дээ. Харин чи цүнхийг цаад гартаа барь. Хоёулаа хөтлөлцөөд явья. Чиний гутал халтирдаг болохоор унаж магад гэж Туяа хэллээ. Би ерөөсөө эмэгтэй хүүхэдтэй хөтлөлцөж үзээгүй болохоор ичиж байсан боловч Туяа ер тоохгүй миний гарыг шүүрч барив. Түүнд би аймхай хулчгар гэж хэлүүлэхээсээ зовж, гарыг нь барьсныхаа дараа аргадуулсан хүүхэд шиг тайвширлаа. Үнэндээ ч миний гутал байн байн халтирдаг болохоор туслах нөхрийн гар намайг түшиж яваа учир айлтүй болов. Тэглээ ч

гэсэн би манай ангийнхан юм уу, өөр эрэгтэй жаалууд харах вий гэж зовсоор байв. Туяа бол тоохгүй. Туяа тийм хүүхэд тааралддаг юм аа ч гэсэн ичиж зовон буруу тийш харахгүй, харин өмнөөс нь зоригтой ширтэж:

- За яадаг юм бэ. Ганзоригийн гутал халтирдаг нь ямар худлаа юм биш. Зүй нь чи ингэж намайг дооглохын оронд нөхрийнхөө цаад талаас түшиж тулах ёстой байсан шүү дээ гэж хэлж чадах байлаа.

Энэ бүхнийг бодохын сацуу би угаасаа Туяаг зарим зүггүй эрэгтэй жаалуудаас яагаад өмөөрдөг болсноо санав. Хэдэн хоногийн өмнө бол би Туяатай ингэж хөтлөлцөн гүйх нь байтугай, тэгж явдаг ч болоосой гэж зөвхөн мөрөөддөг байв. Одоо тэгвэл санамсаргүйгээр хамт явж байна. Хамт яваагаар барахгүй, түүний зөөлхөн хөөрхөн, халуухан гарыг атган явна гээч. Эрэгтэй эмэгтэй хүмүүс хоорондоо яагаад сайн болдгийг би сайн мэдэхгүй. Харин надад Туяатай хөтлөлцөж яваа нь л хамгийн дээд аз байлаа. Магадгүй дайны баатрын эрэл ч бид хоёрыг ингэж ойртуулсан байж болох юм аа.

Өвөө өнөөдөр пингээ барьж байгаа. Орон сууцны хашааны мухарт байх тэр пингийн ойр орчинд зомгол, зоргодос хөглөрчээ. Өвөө банз харуулдаж, үе үе тэгш болж уу, үгүй юү гэсэн мэт ажин харна.

- Өвөө, ядарч байна уу? гэж би хажууд нь очоод асуув.

- Үгүй. За та нар өнөөдөр яав, ямар нэг сураг гаргав уу? гэж өвөө банзаа шагайнгаа хэлэв.

- Тунгаа багшийн ээж Халхын голд сувилагчаар явж байсан. Тэгэхдээ таван сэргийн тухай дуулаагүй юм байна л даа. Харин гүүрийг авсны дараа түүнийг хамгаалж байсан өөр нэг өвөөгийн сургийг гаргаж өглөө гэж Туяа хэлэв.

- Уухайс... Тэгээд тэр хүн хаана байна?

- Мэдэхгүй гэж Туяа далаа хавчив.

- Байх л ёстой. Бид нар олно оо, өвөө гээд би харуулы нь авч, цунхнүүдээ пингийн нэг талаас өлгөөд Туяад,

- Хоёулаа өвөөдөө туслах уу? гэв

- Болно гэж үү хэмээн Туяа гайхав.

- Юу "Болно гэж үү?" гэж?

- Харуул, цүүц, ойл, ерөөсөө энэ багажинд нь гар хүргэж болно гэж үү? хэмээн Туяа асуув.

- Болно. Өвөө зөвшөөрдөг. Харин ч “Мод харуулдаад, пин бариад сурчихвал хожим махны саваа хүн гуйхгүй өөрөө барьдаг болно. Ажил бүхэн эрдэм юм шүү дээ гэсэн” гэж би хэлээд,

- Тийм ээ, өвөө? гэлээ.

- Тиймээ, миний хүү. Үнэхээр л ажил болгон эрдэм. Авигаа, авигаа. Харин хуучин банз л харуулдаарай, шинийг бол хэрэггүй. Өвөө нь янзалж орхисон. Би харуул авч, нэг хуучин банзыг уртааш нь хэвтүүлэн, босоо талаар нь сандлын өнцөгт тааруулаад харуулаа Туяад өгөв. Туяа түүнийг аваад чихэн дээрээс нь барьж,

- Болно гэж үү? гэв.

- Болно, болно. Энэ хоёр бариулаас нь барь гэхчлэн заав. Туяа банзан дээгүүр харуулыг гүйлгэж, анхны зоргодос харуул дээгүүр гогцоорон ирэх үед царай нь гийж:

- Нээрээ, энэ чинь сонин юм байна гэв.

Тэр орой бид хоёр, Тунгаа багшийн эмээгээс бүдэг бадаг сургий нь дуулаад өнөөх гүүр хамгаалагч өвөөгийнх үрүү явав. Тэднийх аймгийн зүүн хажууд, малчны хороололд байдаг ажээ.

Хашаан дотор нь эл хуль, ганц жижиг гэрээс утаа ч гарахгүй байлаа. Бид хоёр явган хаалгаар цувралдан орж, жижиг гэрийн үүдийг зөөлхөн татлаа. Настай эмээ зуухны үнсийг авч байхтай яг тааралдав.

- Сайн байна уу? гэж бид хоёр мэндэллээ. Эмээ хариу мэндлээд:

- Хүүхдүүд минь хоймор гаригaa. Эмээ нь гэж үнс чандруутай ноцолдсон л амьтан байна гээд яагаад ч юм бэ, санаа алдав.

Гэнэт Туяа миний гараас татав. Гайхан харахад тэр хоймрын авдар луу дохилоо. Хархнаа, нэгэн өвөөгийн томоор буулгасан жаазтай зургийг тавьж, хадаг тохоод, өмнө нь зул асаасан байлаа.

- Хожимджээ!

Бид хоёр бие бие үрүүгээ хараад нүдээрээ яг л ингэж хэллээ. Эмээ үнсээ авч гарав.

- Одоо яахав? гэж бид аяархан асуулаа.

- Хүлээе. Шууд гараад явчих муухай шүү дээ. Тэгээд ч хүн эднийхээр нэг их орж ирдэггүй байх. Эмээ биднийг үзээд баярлаж байна шүү дээ гэж Туяа хэлэв.

Би Туяагийнхаа ухаантайд дахин биширч, түүний сэтгэлийн эмзэг хөдөлгөөн надад шилжсэн мэт би бас өрөвдөн хайрлав.

Эмээ ч удалгүй ороод ирлээ. Тэгээд цай аягалж, авдарнаасаа чихэр гарган бид хоёрт атгаж өглөө.

- Бодвол та хоёр талийгаачийн маань цэцэрлэгт явж байсан хүүхдүүд биз. Олон ч жил морь тэрэг хөтөлсөн хүн дээ, хөөрхий. Хүүхдүүд та нар түүнд ямар сайн байв. Бүрлээч ч хүүхдэд хайртай. Ажлаа тараад ирэхэд нь ойр хавийн хүүхэд л морин тэргэн дээр нь шавчихсан байдаг сан. Манай тэр минь ямар уурлаж, уцаарлах биш, тийм л хүн байлаа даа. Гэтэл одоо байхгүй. Иш, хөөрхий зайлуул!

Эмээ ингэж яриад нулимсаа арчив. Туяа ч бас нулимсаа арчив. Миний хоолой зангирлаа.

Зөвхөн сайн сайхан үйлс төдийгүй, бас гаслан зовлон хүмүүсийг ойртуулдаг юм байна гэж би тэгэхэд ойлголоо. Түүнээс хойш Туяа бид хоёр бүр ч ойртсон юм даг.

Гэтэл, өөр харж үзэх хүнгүй тэр эмээгийн тухай ангийнхан дуулангуутаа л “туслах юм сан” гэлцэв. Өвөө бас гэрий нь заалгаж, аав нэг машин түлээ буулгаж, ээж хөвөнтэй дээл оёж өгөх болов.

Ойртоод нөхөрлөөд ирмэгцээ би Туяагийн тогтмол хэлдэг үг, дуу хураагчийн хальс шиг туйлын мэдрэмтгий эмзэг сэтгэлийг нь ойлгов. Туяад би аав ээжийнхээ хэлснийг ярьсан чинь тэр:

- Болно гэж үү? хэмээн асуув.

- Юу?

- Эмээд түлээ буулгаж, дээл оёж өгч болно гэж үү? Тэгсэн чинь эмээ, бусдын гарыг харж амьдрахгүй, өөрөө дөнгөнө гэвэл яана?

Туяагийн энэ үгнээс би, хэрэв Туяа ийм явдалд хүрэх юмаа гэж бодвол чухам л бусдаар тэжээлгэхгүй, өөрөө амьдралын бэрхийн эсрэг сөрөн зогсож чадна гээд хэнээс ч юу ч авахгүй байх нь ээ гэж ойлголоо.

- Хоёулаа эмээгийн дандаа очиж байя, за юу? Яагаад вэ гэвэл чи бид хоёр анхных нь танилууд. Тэгээд ч тусалж байгаа хүмүүс угаасаа сайхан сэтгэл гаргаж байгаа боловч дандаа очоод байж чадахгүй л дээ. Харин бид хоёр л ямагт дэргэд нь байж, юмнаас нь элбэлцэж, сэтгэл санааг нь засч байя. Тэгэх үү?

- Тэгье! гэж энэ удаад би харин зоригтой байж Туяагийнхаа гарыг хоёр алгандаа авав. Туяа юу ч хэлсэнгүй.

Бидний эрэл үргэлжилсээр байлаа. Бид гайхамшигтай зоригтой хүмүүсийн сургийг гаргасаар л байлаа. Тийм хүмүүс яасан ч олон юм бэ дээ. Харин бидний эрэл бид бүхний өөрсдөө ч тааж мэдээгүй нэгэн шинэ зүйл үрүү алхам бүр дагуулсаар байлаа. Энэ бол аавын хэлсэн өнөө нэг үг. Яагаав дээ, “Хүн гэдэг таагдашгүй амьтан” гэдэгтэй холбоотой билээ. Учир нь эрлийн дундуур хүмүүс улам улам ойртож, урьд таньж мэдээгүй шинэ шинэ зүйлсийг бие биенээсээ олж нээсээр байлаа.

Өвөө ажил эрсэн нь

Тэр нэгэн өдөр Туяа өвөөтэй ирж уулзсанаас хойш үргэлж манайхаар ирдэг болов. Гар хүрэх төдийд илтэс, дохиур нь унаж мэдэх сарнай шиг энэ эмзэг, турьхан амьтныг харуул бариад банз харуулдаж зогсоход нь өвөө туйлаас өхөөрдөнө.

- Өдий багаасаа юм юманд авхаалжтай, адтай сүрхий охин гэж өвөө магтана.

Нэгэн удаа Мажигийг Зоригттой дагуулж ирэв. Зоригт хэдийгээр ирэх дургүй байсан боловч Туяа л түүнийг өөрийн эрхгүй үгэндээ оруулжээ.

- Яах гэж? хэмээн Зоригт гайхав.

- Зоригт гэж сайн хүү байдгийг өвөөдөө үзүүлнэ. Чамайг очоод, өвөөгийн барьж байгаа пинд ганц хадаас хадаад өгөхлөөр, өвөө ихэд баярлаад,

- Өдий багаасаа юм юманд авхаалжтай, адтай сүрхий хүү юм гээч гэж магтана. Настай хүнээр тэгж магтуулах чинь сайхан явдал биш гэж үү? гэв.

Ангийнхаа хоёр найзын үгнээс Зоригт татгалзаж чадсангүй. Бас тэгээд үнэхээр өвөөгөөр магтуулах сан гэсэн хүсэл нь дийлжээ.





“Зоригт биднээс хөндий байдаг нь буруу. Бид ч түүнийг зожиг юм гээд нөхөрлөдөггүй нь буруу. ← **мажиг**: Тийм хүүхдийг бид л татаж авахгүй бол хэн тэгэх юм бэ?” гэж Туяа хэлдэг билээ. Чухам нөхрөө гэсэн бодол нь Зоригтыг өвөө дээр авчрахад хүргэсэн хэрэг. Өвөө энэ үед пингээ барьж дуусгах шахсан байлаа.

- Өвөө, бид дөрөв танд тусалъя тэгэх үү? гэж Туяа болгоомжтой асуулаа.

- Тэгэлгүй яахав, Ганзориг та хоёр харуулдаж чадна. Энэ хоёр хүү хадаж чадах байлгүй. Өвөө нь зааж өгье.

Бид дөрөв өвөөдөө тусалж, пингийн дээврийг хадаж дуусгав. Тэгээд ажил дууссаны дараа Туяа хэлсэн нь:

- Өвөө та эмээгийн хуучин пинг засч өгөөч. Тэр нь цоорхой болохоор эмээгийн идэж уух юмыг нохой шомбодоод байна гэнэ.

Туяа ийм л сүрхий охин. Би тэгэхэд ердөө ч энэ тухай санасангүй. Бид хоёр хоёулаа очиж, эмээтэй баахан ярьж суугаад, гурвуулаа пинд гарсан том нүхийг гөлмөн төмрөөр таглаж, наанаас нь баахан мод, чулуугаар дарсан билээ.

- Зөв дөө, охин минь. Тэгвэл тавуулаа очиж, тэр пингий нь янзалж өгөх үү? гэж өвөө хэлэв.

- Тэгье. Ядарсан хүнд туслах чинь буянтай үйлс шүү гэж Мажиг эхлэв.

- Тэднийх чинь халх голын дайны баатрынх. Цэргийн ар гэрт туслах ёстой юм шүү гэж өвөө хэлэв.

Орой өвөө бид хоёр өрөөндөө байлаа. Өвөө шалан дээр гудас дэвсээд сууж байв. Цээжээ нүцгэлээд гаансаараа далныхаа хооронд маажиж, шилээ шөргөөнө.

- Одоо ч хүү минь, өвөө нь пингээ дуусгав. Айлын пинг засахад ядах юмгүй. Тэгээд өвөө нь ажилгүй болно гэснээ, үгүй, өвөө нь ажилгүй сууж чадахгүй. Миний зан тийм юм. Урт өдрийг ажилгүй өнгөрөөх шиг зовлон алга. Яая даа, байз гэж өвөө хэлэв.

- Та ажил хийвэл болохгүй юу? гэж би асуулаа.

- Чи яасан ухаантай хүүхэд вэ? Нээрээ ажилд орвол зүгээр сэн. Мужааны ажил хийдэг сэн бол би дөнгөөд л байна даа гэв.

Маргаашнаас нь Туяа бид хоёр өвөөд ажил олох юм болов.

Харин өвөө хаанаас ч дуулсан юм бэ, Туяа бид хоёрт аминчлан хэлсэн нь:

- Гүүрийн тулалдаанд хамгийн эрэлхэг байлдсан зоригтой хүн байна гэнэ. Аймгийн тээврийн бааз дээр та хоёр очооч. Хайдав гэдэг жолоочийг сурагла. Хэрэв тээвэрт гараагүй байвал уулзаж ярь. Тэр хүн чинь гүүрийг эзлэхэд хамгийн эрэлхэг байлдсан хүн мөн. Би бүр лавтай мэдэх хүнээс дуулаа гэв.

Бид хоёр ихэд баярлав. Магадгүй, Хайдав гуай үлдсэн гурван хүнийхээ нэрийг ч хэлж өгч болох юм.

- Явья явья, гэж би Туяаг яаруулав.

- Болно гэж үү? хэмээн Туяа үүдний өрөөнд асууж байна.

- Юу? гэж би гайхав.

- Үнэхээр болно гэж үү? Аав ээж хоёр чинь, бас ээжийн чинь үерхдэг авгайчууд, манай ангийнхан цөмөөрөө гавьяатныг хайж байхад бид хоёулхнаа уулзаж болно гэж үү?

Туяа ийм л сүрхий. Амиа бодохгүй, бусдыгаа, нөхдийгөө бодох нь Туяагийн онцгой чанар байсан хэрэг.

- Болно. Бид хоёр зөвхөн сургий нь гаргаж өгөх л гэж явж байна. Түүнээс биш Хайдав гуай бид бүхний л олсон баатар хэвээрээ байх болно гэж би баталлаа.

- За тэгвэл очье гэж Туяа зөвшөөрөв.

Хайдав гуайг бид хоёр баазын гадаа бензинийхээ шүүлтүүрийг шэвэрлэж байхад нь очив. Энэ бол хууз сахалтай туранхай хүн юм.

- Сайн байна уу, Хайдав гуай? гэж Туяа мэндлэв.

- За чи хүрээд ирэв үү? Би одоохон бензин шүүлтүүрээ шэвэрлээд орхиё. Чи бүхээгт ороод сууж бай. Би удахгүй. Тэгээд хөдөлгөөнө гэж Хайдав гуай нүд ирмэн хэлэв.

- Хаашаа? гэж Туяа гайхлаа.

- Юу хаашаа гэж? харина гээ биз дээ. Галтай Булнай уруу л нисч орхиё! Ямар Алтай таван богд явалтай биш.

- Үгүй ээ ахаа, Туяа явахгүй. Энднийх чинь аймгийн төвд байдаг юм байхгүй юу. Харин ...

- Юу гэнэ ээ? Аймгийн төвд өө? Тэгвэл чи Цэрэндашийн хэлсэн хүүхэд биш байх нь ээ?

- Биш. Бид хоёр таныг яаж Халх голд байлдсаныг чинь яриулах гэсэн юм байхгүй юу! Хайдав гуай айсан юм шиг бид хоёр луу харав.

- Хэн тэгж байна? гэж тэр бүр ичсэн мэт аяархан асуув.
- Бид нар мэдсэн юм. Та Халх голын баатар, тиймээ? гэж би асуув.

Хайдав гуай шүүлтүүрээ буцаан тавихдаа юу ч хэлсэнгүй. Тэгээд түлхүүр багажаа хураан гарынхаа тосыг арчаад:

- Халх голд байлдсан Хайдав гэгч нь би мөн л юм биз дээ? гэж асуув.

- Мөн!

- Хэн тэгж байна?

- Тантай хамт байлдаж явсан хүмүүс. Өөрөөр хэлбэл та дөрвөн нөхдийнхөө хамт дайсанд эзлэгдсэн гүүрийг чөлөөлж, давшилтанд их тус хүргэсэн юм билээ гэж Туяа хэлэв.

- Аа тийм үү гэж Хайдав өөрийн тухай биш, харин өөр ямар нэг хүний тухай сонссон мэт гайхаад:

- За тэгвэл суу? гэж бүхээгээ онгойлгов. Туяа бид хоёр "Аймгийн 3 удаагийн аварга тээвэрчин" гэсэн бичигтэй хаалгыг дотор талаас нь хааж, Хайдав гуай тэргээ асаав. Тэгээд хөдөлж, Зуу модны гол өнгөрөөд зогслоо. Дараа нь суудлынхаа араас цүнхээ гаргаж, дотроос нь боов боориог, хиам чихэр гарган бид хоёрыг дайлав. Бид хоёр юу ч болоогүй байхад гэнэт дайлуулах болсондоо гайхасхийн, идэх юмнаас дөнгөж л амсах төдий ам хүргэв.

- За тэгээд, яаж гэнэ ээ? Би Халх голд байлдсан байх нь үү?

- Тиймээ, та байлдсан гэж Туяа хэлэв.

- Одоо би тавин долоотой. Тэгэхлээр дөчин жилийн өмнө... арван долоотой байсан хэрэг үү?

- Яг тийм гэж би батлав.

- Тэгвэл худлаа. Цэрэгт чинь арван наймаас дээш насны хүмүүсийг татдаг юм шүү дээ. Энэ тухай хэнд ч битгий хэл, за юу? Хүн юу ч гэж бодох билээ. Огт худлаа юманд нэр холбогдох шиг эвгүй юм байхгүй.

Харин би тэр гүүрэн дээр хэн хэн байсныг л хэлж өгье. Түүнийг яаж мэдсэн нь бас нууц. За юу? Тиймээ, тэр гүүр лүү таван цэрэг явсан юм гэнэ билээ. Нэг нь одоо манай аймгийн төвөөс холгүй газар бий. Дэндэв гэдэг юм. Хоёр дахь нь танай сургуульд жижүүр хийдэг өвгөн. Гурав дахь нь Улаанбаатарт... Дэмбэрэл гэдэг юм, театрын жүжигчин... Дөрөв дэх нь баруун

аймгийн нэг хүн байсан... Тэр тавын ахлагч нь... Харин би тав дахийг нь мэдэхгүй. Хаана ч байдгий нь дуулаагүй.

Тэгэхдээ олигтой юм хийсэн хүн биш байх. Та нарт тэр хүмүүс бүр зайлшгүй хэрэгтэй юм уу? гэж Хайдав гуай асуулаа.

- Зайлшгүй хэрэгтэй!

- Тэгвэл би баруун аймгийн тэр хүнийг сураглаад орхиё. Харин миний ярьсан нь нууц. Надтай уулзсан нь нууц. За юу?

Туяа бид хоёр бие бие үрүүгээ жуумалзан харав. Туяагийн хари "Үнэхээр энэ тухай нууж болно гэж үү?" хэмээн надад хэлж байлаа. Хайдав гуай бас хэлсэн нь:

- За яахав, би бас тэр тав дахь хүнийг олж өгсөн ч болно. Харин надтай уулзсан нь нууц хэвээр үлдэг. Энэ тухай хэнд ч хэлж болохгүй. Хэрэв нууцыг хадгалж чадах юм бол би баруун аймгийн хүнийг (тав дахь хүнийг) олж өгөхөөр барахгүй, шагнах болно. Ингээд "за" гээд баталчих уу?

Бид хоёр нэг л мэдэхэд Хайдав гуайтай гар барьсан байна. Тэгээд дараа уулзахаар боллоо. Хайдав гуай бид хоёрыг сургуулийн хажууд хүргэж өгсөний дараа Туяа:

- Ямар сонин юм бэ? гэлээ.

- Юу?



← Үгээр
Хайдав.

- Хүмүүс... Хүмүүс ер ямар сонин, ямар гайхалтай өөр өөр зантай юм бэ? Ганзориг оо, би 45 онд зүүн зүгт чөлөөлөх дайныг удирдаж явсан нэг хүний дурдатгалыг уншсан юм байхгүй юу. Тэгсэн чинь ингэж бичсэн байна билээ.

Говьд “Угалз” гэдэг шуурга болдог юм байна л даа. Тэнгэр элс гэдэг их элсний тэнд манайхных явж байхад тэр угалз болж гэнэ. Хоёр цагийн хэртээ аймшигтай их шуурга болжээ. Тэнгэрт өнөөх элс нь тэр чигээрээ салхинд босоод, хавь ойр юу ч үзэгдэхийг байжээ. Тэр аймшигт шуурганы дараа харсан чинь эргэн тойрон юу ч байхгүй, элсэн толгодоос өөр ямар ч бараа харагддаггүй гэнэ. Харин хэдхэн мөчийн дараа өнөөх элсэн толгод гэв гэнэт овсхийтэл хөдөлж, давшиж явсан их армийн унаа машин, цэрэг дарга нар элсэн доороос ярсхийтэл босч, тулалдаанд орсон юм гэнэ билээ. Сонин шүү.

- Тэгээд?

- Би бодох юм. Их шуурганы дараах тэр элсэн толгод дунд байсан шиг бид нар чинь нэг хэсэг нүдээ ч сайн нээж харахгүй, эргэн тойронд маань ямар хүмүүс байгааг ч мэдэхгүй гайхаж байж шүү дээ. Харин одоо бол бид нар гавьяат хүмүүсийн эрэлд гарч, хүн хүнтэй уулзсаар байгаад ярсхийн боссон элсэн дор нуугдсан хүмүүсийг гэнэт олсон шиг л юм болжээ. Одоо бол бид хүн хүний царайг сайн харж ялгаж байна, тийм үү? гэв.

- Тийм ээ.

Надаас түрүүнд Туяа тэр номыг уншихсан байсанд би жаахан зовов. Уг зүй нь би л эхэлж уншаад энэ зүйрлэлийг Туяадаа хэлсэн бол онох байж. Харин Туяа сүүлчийн зүйрлэлээрээ ахиад намайг бишрүүлэв. Би түүнээс дахиад шинэ зүйлийг олж нээлээ.

Өвөө биднийг дагуулж эмээгийнд очоод пингийнх нь онгорхой цоорхойг бөглөж, засч өгсний дараа, хоёр хоноод Тунгаа багш манайд ирлээ. Ганцаараа ч бус ангийн хэдэн охидтой ирэв. Бид гайхамшигт хүмүүсийг эрсээр байгаа билээ. Багшийн дэвтэр дээр тэмдэглэсэн, дайн тулалдаанд орж үзсэн аймгийн төвийн хүний тоо тавь өнгөрөөд явж байв. Түүгээр ч барахгүй, баруун хязгаарт, Архангайн Тариатад, зүүн зүгт эсэргүү лам нарын бослогыг дархад оролцож байсан, аавын хэлдгээр “Маш ховордсон амьтад” ч байв. Харин гүүр эзэлсэн таван цэрэг л бүгдээрээ олдсонгүй.

Хэрэв Хайдав гуай инээд хүрмээр юм хэлж, сэм зугтсан бол, сургуулийн манаач Дорлиг гуай, бусад дөрвөн цэрэг юу ч биш, хамгийн гайхалтай эрэлхэг зоригтой хүн нь би өөрөө байсан гэж хэлэх шахав. Инээдтэй өвөө шүү.

- За та нар жуумалзаж байна уу? Тэгвэл, аан гэж бай. Тэр гүүрэн дээр хамгийн аюултай дайсан нь пулемётчин байв. Түүнийг л устгаж гэмээ нь ялалт болох байсан. Би тэгээд мөлхөөд, өнхрөөд, дөхөөд л байлаа. Ганц үг хэлүүлэхгүй сэмээрхэн устгана шүү дээ. Тэгэхгүй бол бусад нь мэдээд, баллаж орхино. Би ч хулгананд гэтсэн муур шиг л мөлхөөд байв. Дэргэд нь шахам очоод ганц үсэрч... хэмээн өвөө хажуудаа байгаа дайсныг яаж барьснаа үзүүлэх гэж Мажигийг өвдөл цохисонд,

- Ёо ёо, гээд Мажиг зайлсхийв.

- За ийм л байгаа юм даа. Хэрэв тэр пулемётчинийг устгаагүй бол давшилт эхлэхгүй байсан юм. Ойлгов уу? Бид Дорлиг гуайн үгэнд итгэж, түүнийг гүүр эзлэхэд хамгийн эрэлхэг байлдсан гэж тооцож байтал хотоос захиа ирэв. Машинаар цохиж, гарын үсгээ зурсан тэр захиаг драмын театрын жүжигчин ах Дэмбэрэл бичсэн байлаа.

Дэмбэрэл гуай бичсэн нь: "Он цаг урссаар байна. Тэр үйл явдал он цагийн урсгалд биднээс улам улам холдсоор л байна. Та нар үнэхээр буянтай сайхан үйлс эхэлжээ. Гайхамшигтай зориг зүрхтэй, эрэлхэг, тийм хүмүүс бидний дунд одоо хүртэл байсаар боловч харин судлан сурвалжлах ажил маань хоцорч байна уу даа гэж би боддог. Манай тасгийн дарга Дамдин чухам л тийм зоригтны нэг. Тэр хүн гүүр эзлэхийн төлөө яаж тулалдсаныг хэн ч мэдээгүй өнгөрчээ. Тухайн үед нь хэлж яриагүй бидний ч буруу байж болох юм.

Ер нь дайнд тийм явдал тохиолддог л доо. Цэрэг эрийн хийсэн хамгийн энгийн, өчүүхэн юм шиг үйлс бүх армийн давшилтанд хамгийн том үүрэг гүйцэтгэсэн байх ч удаа байдаг. Тасгийн дарга Дамдин тийм л хүн. Тэрвээр ганцаараа явж, зориг самбаатайдаа гүүрийн тэхий голд зоосон пулемётад хүрч, ганц ч дуу гаргалгүйгээр дайсныг барьж, түүний хүчээр бид хэд гүүрийг эзэлсэн юм. Би тэгэхэд шинэ цэрэг, гартаа гранат бариад гүүрнээс зугтсан дайсан уруу шидэж, ар талдаа хэл хүргэж замы нь зааснаас биш өөр гавьяа үгүй. Бусад маань мөн адил, Эндэв анхны харуулыг, Дорлиг пулемёт хамгаалж байсан цэргийг,

Хайдав гүүрнээс зугтсан дайсныг устгасан юм. Ганцхан бүх ялалт Дамдингаас шалтгаалсан гэдгийг бид ойлгож байлаа.

Би тасгийн даргаа эрээд олохгүй л явна. Бид л түүнийг олж гавьяаг нь тодруулж, олонд хэлж өгөхгүй бол Дамдин шиг даруухан хүн хэзээ ч, яагаад ч өөрийнхөө тухай хүнд ярихгүй нь ойлгомжтой. Дамдин надад олдохгүй байна. Хуучин ажлаасаа лав яваад өгсөн бололтой. Хэрэв сураг гарвал та нарт заавал хэлэмз...”

- Ямар сонин юм бэ? гэж Туяа тэгэхэд дуу алджээ.

- Тэгвэл, Дорлиг гуай чинь ёстой... гэж Мажигийг эхлэхээр “Худлаа хэлдэг хүн байжээ” гэж үгийнх нь төгсгөлийг бид төвөггүй ойлгов. Тунгаа багш хэлэх нь:

- За яахав вэ, учир нь олдох вий. Бид гайхамшигт хүмүүсийн эрлээ үргэлжлүүлж л байя. Харин Ганзоригийн өвөөтэй уулзаж ярих юм байна. Тэр өвөө таван цэрэгийн тухай үнэхээр хэрэгтэй сургийг бидэнд гаргаж өглөө. Бид түүнээс сураг сонсчихоод л, баярлаад л гүйж явж зохихгүй. Өвөө ажил эрж байгаа гэсэн. Бүгдээрээ түүнд тусалъя. Тэгэх үү?

- Тэгье! гэж бид нирхийтэл хариулав. Тунгаа багш миний орон дээр сууж өвөөг удаан гэгч ажигласнаа,

- Өвөө та ажил хийхсэн гэж бодоо юу? гэж асуулаа.

- Тиймээ, би ч уг нь мужаан хүн юм шүү дээ...

- Та цэцэрлэгийн нягтлан бодохын ажил хийж чадахгүй гэж үү? хэмээн нэг охин асуугаад,

- Аав цэцэрлэгийн эрхлэгч юм байхгүй юу. Нягтлан бодох нь шилжээд явчихсан болохоор... гэв.

- Үгүй, түүнд чинь мэргэжилтэй хүн хэрэгтэй. Өвөө нь мод харууллахаас өөр юм мэдэхгүй гэж өвөө толгой сэргэв.

- Тэгвэл та манаач болох уу? Дөрөвдүгээр дэлгүүрийн манаач өвдөөд... гэж нэг нь асуув

- Тэр ч бас юу л бол... гэж өвөө хэлээд

- Хүүхэд минь зоволтгүй. Би өөрөө л ажлаа олъё. Харин ажлыг бол хийнэ шүү. Тэтгэвэртээ гарсан ч гэсэн ажилгүй сууж бүр чадахгүй. Би ер нь хуучин ажилдаа очвол яасан юм бэ? Яагаав дээ, нэгдэлдээ. Мужаан олоогүй л байгаа даа цаадуул чинь. Ингээд яваад очих юм гэхэд намайг өөрийн хүн гээд л авна.

- Та явах гэж үү? хэмээн би айсан мэт дуугарав.

- Болно гэж үү? хэмээн Туяа асуулаа.
- Юу болно гэж үү гэж!
- Та ганцаараа амьдарна. Түлээ түлшийг тань хэн ойртуулж, хэн ус авч өгөх юм бэ? Бас...

- Зүгээр хүү минь, зоволтгүй. Болоод л ирсэн юм. Тэнд бас надад тусалж байдаг хөөрхөн жаалууд бий. Та нар харин өнөөх таван цэргийн сургийг гаргаж авлаа. Түүнийгээ л сайн хөөцөлд, олдох л ёстой. Нэгэнт сургий нь гаргасан болохоор би зовох юмгүй болов. Ингээд өвөө нь нутаг буцдаг хэрэг үү дээ, аан?

- Үгүй, та түлээ... Бид танд заавал ажил олж өгнө! гэж Тунгаа багш гуйв. Багшийн дууны өнгөнөөс би өвөөг яваад өгөх вий гэж айсан болгоомжлолыг олж мэдлээ.

- Болно гэж үү? хэмээн Туяа аяархан асуув.

- Өвлийн энэ хүйтэнд өвөө та явж болно гэж үү? Дулаархыг хүлээхгүй ээ?

- Юу ч гэсэн бодье, хүүхэд минь, бодье. Бодон байж шийдье.

Тунгаа багшийг явснаас хойш би өвөөгөө өрөвдөн бодсоор л байв. Өвөөд минь нээрээ л ажил хөдөлмөр, амьдралынх нь гол зүйл юм байж. Ажилгүй л бол өвөө үйдаж, гаансандаа хэдгэнэ хийчихсэн юм шиг дуугарган, алсын уулын толгой ширтэж юм бодож суудаг билээ. Гэтэл өвөөгийн хийх ажил аймгийн төвд тийм ч амар олддоггүй бололтой.

- Тэр Бавуу гэгч чинь таван цэргийн нэг нь мөн юм байна гэж ээж гаднаас дуу алдсаар орж ирлээ.

- Ямар Бавуу?

- Яагаав дээ, өнөөх жолооч Бавуу! Туяа та хоёртой уулздаг Бавуу...

- Хайдав гуай юу да гэж намайг инээхэд ээж:

- Тийм тийм, Хайдав. Бид гэрээр нь очлоо л доо авгайтай нь ярьж, үнэмлэх бичгий нь ч үзлээ. Өөрөө даруухан хүн болоод л хүнд ярьдаггүй юм байна. Байлдах нь ч байлдсан хүн юм аа гэжээ.

Нууц тайлагдахад

Бид өвөөгийн сэтгэлд таарсан ажил олж чадсангүй. Аав зам засварынхаа газарт оруулья гэсэн боловч өвөө зөвшөөрсөнгүй. Ээж бас таньдаг хүн үрүүгээ ярьж, дэлгүүрийн ачаа ачигчаар ажиллуулах гээд ч нэмэр болсонгүй. Тэгж байтал цагаан сарын дараахан нэгдлээс захиа ирэв. Өвөөгөөр мужааны мэргэжил заалгасан шавь нар нь тэр захиаг бичжээ. “Таны эзгүйд бид хэд үнэхээр эвгүй байгааг та төсөөлж ч байгаа байх. Хэдийгээр та урин дулаан цаг болохоор ирнэ гэсэн боловч бид одоо л ирээсэй гэж тэсэн ядан хүлээж байна. Хэрэв таныг ирвэл таны тусалцаатайгаар сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга дээр ажилламаар байна. Тэр цэцэрлэгийн цонхноос нь эхлээд хээ угалзаар чимж, дотор талынх нь гоёлыг үнэхээр нэг мужааны үр гаргаж хиймээр байна” гэж бичээд, төгсгөлд нь “Ирээч, ирээч” гэж хоёр дахин бичиж анхаарлын тэмдэг тавьжээ. Бид энэ захианаас бас нэг шинэ зүйлийг нээв. Одоо л мэдэхнээ өвөө маань халамжлан хүмүүжүүлэгч юм байж. Өвөөгийн маань гар хуруу эрдэмтэй, “мод амь оруулдаг” тэр гар хурууны эрдэм нь над шиг ч юм уу, надаас ах ч юм уу хэдэн хүүхдийн амьдралын, ажлын гол зүйл болсон байх нь ээ гэж би бодлоо. Харин өвөө захиа авмагц л явна гэж бүр яарав.

- Болно гэж үү? хэмээн дуртай үгээ Туяа давтав.

- Юу?

- Халамжлан хүмүүжүүлэгч хүнийг шавь нар нь дуудаж байхад явуулахгүй байж болно гэж үү?

- Тэгвэл өвөө нь нутагтаа очоод ах дүү, үр хүүхэд, төрөл садангүй юм чинь яаж амьдрах юм бэ гэж Мажиг хэлэв.

- Хэн түүнд ус авч, түлээ хагалж өгөх юм бэ? гэж Зоригт асуулаа.

- Хөдөлмөрийн хамт олон гэдэг төрөл төрөгсдийг нь орлодог ёс бий. Дамдин өвөө тийм хамт олонтой хүн. Багшийгаа ирээч гээд байгаа тэр шавь нар нь өвөөд тусалж таарна гэж багш их юм бодон хэлээ.

- Тэгсэн чинь бидний бүр ажил удаж эрээд байгаа таван цэргийн үйл явдал бас л тодорхой болоогүй байна.

- Пулемёт устгасан тасгийн дарга Дамдин гэгч хэн бэ? Арай энэ чинь өвөө биш биз. Нэр нь адилхан юм байна шүү дээ! гэж Туяа хэлэв.

- Яалаа гэж. Хэрэв тийм сэн бол өвөө дуугүй байхгүй. Үнэнээ хэлэх байсан. Хэрэв тийм сэн бол өвөө таван цэргийн эрэлд бидэнтэй хамт гарахгүй байсан.

- Тэр ч тийм гэж багш хэллээ.

- Өвөө маань уг нь таван цэргийн гавьяаг тодруулж дууссан хойно бидэнтэй тэр гайхамшгийг нээлцсэний хувьд хамт баярлах ёстой байсан гэж Туяа хэлэв.

- Оронд нь аав тэр хүмүүсийг эрж олоход бидэнд тусална гэсэн. Өвөө, аавд түүнийг даалгасан юм гэж би хэлэв.

Өвөө хот уруу явах гэж машин хүлээж, манай ангийнхан цөмөөрөө ирчхээд орны гадаа ингэж ярьж байлаа.

Удсангүй аав машин олж ирэв. Өвөө маань богиоо бариад инээмсэглэсээр гарч ирлээ. Тэгээд эхлээд багштай гар барьж, бүх хүүхдүүдийг үнсээд, дараа нь ээж бид хоёрын духан дээр хошуугаа хүргээд машинд суув. Жижиг саарал тэрэг өвөөг маань нийслэл үрүү авч хөдөллөө. Аав хүргэж өгөхөөр явлаа.

Өвөө гэнэт яваад өгсөн нь надад гайхалтай санагдана. Өвөөдөө ямар ч тус үзүүлэлгүй харин ч зарсаар байгаад явуулчихсандаа би гомдов. Бид нээрээ ямар тэнэг бүдүүлэг, загас шиг хайхрамжгүй нүдтэй хүмүүс вэ. Өвөөг минь хүндэтгэн хайрладаг өөр хүмүүс байдаг нь надад сонин санагдана. Тэр “Хөдөлмөрийн хамт олон” гэгч ямар хүмүүс юм бол оо? Өвөө өөрт зохицсон эрдэмтэй, халамжлан хүмүүжүүлэгч хүн байхад бид түүний нь мэдээгүй байна шүү.

Ингээд бодохлоор “Хүн гэдэг танигдашгүй амьтан. Хүнд ямар их хүч чадлын ид шид байгааг хэн ч нээж олоогүй хэрэг!” гэж аавын хэлдэг нь үнэн болж таарлаа. Өвөө хөдөөнөөс ирээд хэдэн сар болохдоо манай гэрийнхний дотор үргэлжийн найрсаг сайхан сэтгэлийн үр тарив. Тэр бас хүн болгоны нүдийг нээж, алив нэгэн гайхамшигт үйлс тийш дуудав. Өвөө өөрөө зүгээр сууж чадаагүйгээрээ надад ч, аавд ч нөлөөлж, бид юу ч хийхгүй утга учиргүй суух нь ямар гунигтайг мэдэрсгээв.

Өвөөгийн минь энэ сайхан чанар зөвхөн манай гэрийнхэнд ч биш, бас ангийнханд маань, ээжийн үерхдэг авгайчуудад хүртэл

нөлөөлсөн хэрэг байх аа даа. Хүн болгон л таван цэргийн тухай ярих болмоо. Өвөө бас шууд биш боловч далдын ид шидээрээ Зоригтод нөлөөлөв. Өвөө дээр Туяатай хамт ирснээс хойш Зоригт аливааг хөндлөнгөөс ажиглахыг байж, өөрөө оролцдог болов. Мэдээжээр, түүнд Туяа тус хүргэсэн л дээ. Өвөөг онгоцонд суугаад Баянхонгор луу ниссэний маргааш, өөрөөр хэлбэл, өвөөг үдэж явуулчаад ирж, ажилдаа орсон тэр өдрийн орой манайд нэгэн хүн ирлээ. Өвлийн хар захтай пальтотой, өндөр нуруутай настай хүн байв. Тэр хүн үүдний өрөөнд гутлаа арчиж, хаалгаар айсан мэт шагайн хараад:

- Дамдин мужааны хүүгийнх мөн үү? гэж асуулаа.

- Мөн, мөн! гэж ээж гайхаад

- Та орооч... гэв.

- Би... жүжигчин Дэмбэрэл гэдэг хүн. Дамдингийн сургийг гаргаж яваа нь энэ дээ. Тэр хаана байна? гэснээ тэр ах пальтоныхоо захыг буулган, өвөөг гаргаад ирвэл тас тэвэрч авья гэсэн мэт зогслоо.

- Яваад өгсөн гэж урамгүй хэлэв.

- Хаашаа?

- Баянхонгор луу, нутаг уруугаа...

- Хэзээ тэр вэ?

- Дөнгөж өчигдөр. Би гаргаж өгөөд ирсэн юм л даа гэж тэгж явсан нь буруу юм шиг аав аяархан хэлэв.

- Та суугаач. Цай уу! гэж ээж сандрав

- Үгүй мөн сайхан "оргодол оо" хөөе! гэж Дэмбэрэл гуай дуу алдаж,

- Сурагласаар байгаад хүрээд ирэхэд яваад өгдөг байна шүү гэв.

- Та тэгээд ааваар яах гэсэн юм бэ? гэж ээж асуув.

- Ийм учиртай юм. Танай сургуулийн хүүхдүүд Халх голд гүүр эзлэх үеэр болсон явдлыг сонирхож, надад захиа бичсэн юм. Хамгийн их үүрэг гүйцэтгэж, дайсны пулемётыг дуугүй болгож, бид дөрвийг байлдаанд удирдсан Халх голын зоригт эр, тасгийн дарга Дамдин гэгч чинь тэр шүү дээ гэж Дэмбэрэл гуай бахдалтай хэлэв.

- Юу? гэж аав ээж бид гурав дуу алдашгаав. Эрээд байсан хүнээ хажуудаа байхад мэдэлгүй байсаар явуулж орхидог бид гурав ямар тэнэг юм бэ.

- Тийм ээ, хүүхэд минь. Дамдин гол хүн нь мөн. Харин тэр тухайгаа хүнд ярьж явах ч хүн биш ээ. Тиймэрхүү хүмүүс цахиур шиг дуугүй боловч гал гаргах чадалтай байдаг юм шүү гэж Дэмбэрэл гуай хэлээд:

- Бусдад маань энэ зураг байхгүй байх. Бид л эрж сурж байж олж авсан ганц зураг энэ юм даг. Май үзэцгээ. Таван цэргийн голд нь зогсож байгаа хүн өвөө чинь. Залуухан ч, сайхан ч байсан юм даа. Цаана харагдаж байгаа нь бидний чөлөөлсөн өнөөх домогт гүүр мөн. Халх гол бас харагдаж байна гэлээ.

- Би зургийг авч удаан гэгч харав. Инээмсэглэн зогсож байгаа өвөөгийнхөө залуугийн зургийг би ажиглаж байгаад танив.

- Мөн байна!

- Ёсоороо!

Аав ээж хоёр ингэж дуу алдан байхад би яагаад ч юм бэ, уйлмаар санагдаж байв. Тэгтэл бас өвөөгөөрөө бахархах сэтгэл төрж, “Миний өвөө ийм мундаг хүн” гэж ангийнхандаа очиж хэлмээр санагдана.

Битэгээд сэмээрхэн гарлаа. Өвөөгийнхөө тухай ангийнхандаа хэлж, тэднийг Дэмбэрэл гуайтай уулзуулах сан гэж би яарч байлаа.

“Их үйл явдлын ул мөр ямар нэг зүйлд заавал хүргэдэг нь үнэн юм байна. Өвөөг дөнгөж ирж байсан үеийг би эргэн санаад Туяагийн ярьсан “УГАЛЗ” хэмээх шуурганы хөрөг зургийг сэтгэлдээ төсөөллөө. Ямар ч шуурга болсонгүй. Харин гайхамшигт баатрын эрэл маань бидний төлөө амь дүйн тулалдаж явсан олон олон хүн, музейн шилэн үзмэр шиг бус, харин бидний эргэн тойронд амьдарч ажиллаж байгааг харуулав. Тэр хүмүүс эгэл даруугаараа гайхамшигтай бөгөөд хэзээ ч өөрийгөө “Би баатар байна” гэж хэлдэггүйг ойлгуулав. Тэгсэн чинь зарим нь биднээс холдож байв. Өвөө шиг зарим нь өөр аймаг уруу нисч, харин өнөөх нэгэн эмээгийн гэрт байсан зургийн ижил, хүн бие нь биднээс бүр холдоод, зөвхөн зул асаасан зураг нь үлджээ...”

Бид хайхрамжгүй нүдтэй байж болохгүй. Харин соёмбон дээр байдаг загасны нүд шиг ямагт цавчралгүй харж байж, тэр эрэлхэг хүмүүсээ олж тодруулах ёстой юм байна!” гэж би бодож явлаа.

1981 оны 1 сарын 24

АМЬД ТУНХАГ

Аав ирж, нар гарлаа.

Аав минь цэрэгт яваад гурван жил болсон боловч сураг чимээ бүр тасарсан юм. Тэр үес, алс газар явсан хүний амьд үхсэн нь мэдэгдэхгүй, мэдэгдэхийн нөхцөл ч байсангүй цаг шүү дээ. Одоотой адил харилцаа шуудан гэж байх биш. Ганцхан, төрийн алба залгуулдаг буухиа элчээс өөр харилцаа байсангүй шүү дээ. Тэгэхлээр сайндаа л аян жингийн хүн эргэлчин мөргөлчнөөс худал үнэн сураг дуулахаас хэтрэх биш дээ!

Тэгтэл зуны эхэн сарын нэг сайхан өдөр манай гэрийн зүг нэг үхэр тэрэг залхуутай гэлдэрч айсуу харагдав. Манайхан аавын тухай өдрийн бодол шөнийн зүүд байснаас хүрээ зүглэсэн тоост нарийн замыг өглөө үдэш, өдөр шөнөгүй саравчлан тэр замаар нохой ч гарч ирсэн л горьдож байсан болохоор үхэр тэрэг ирнэ гэдэг ч их баяртай сайхан хэрэг байж билээ. Үнэхээр баярт явдал болж аав минь тэр үхэр тэргээр ирлээ. Гэвч аав минь баруун хөл нь гэмтчихээд бургасан таяг түлжээ.

- Энэ хөлнөөс л болж цэргээс халагдлаа шүү дээ! гэж нарийн бургас модоор чиг барьж боосон оймстой хөлөө заагаад,

- Энэгүй бол ч одоо цагт цэргээс халагдана гэдэг ноёдоос хишиг горьдохтой адил болсон цаг гээд цагаан шүдээ яралзуулж инээхэд манай муу бор гэрт цугласан хүмүүс даган шуугилдаж,

- Энэ ч аз л даа! Тэнд зовлонгоо эдэлснээс яс хугарах ч яахав. Сайн бариач барьсан бол удахдаа л сарын хугацаа шүү дээ гэлцэнэ.

Гурван жил өдрийн бодол шөнийн зүүд болсон аав минь ирж тэр өдрийн бүгчим халуун нарны хажуугаар миний жаргалын нар гарч байна.

Бүгд сонсогтун!

Аавыг автономитын цэргээс халагдан ирсэн сураг, цай болохын зуур л хавь ойрт таржээ. Тэр өдөр манай муу элэгдэж навтайсан босгон дээгүүр хэчнээн хүн алхсан гэж санана. Манай аавын найзуудаас эхлээд л доголон Хайдав, Долой захирагч хүртэл баяд ихэс манайд ирж ааваас хүрээ газрын сонин, цаг төрийн байдлыг лавлаж, үгэнд дурлацгаав. Тэгэхэд аав:

- Цаг төрийн байдал ч цэрэг бидэнд яаж тодорхой дуулдахав дээ. Ер нь л жаахан ширүүвтэр байх шиг байна.

- Гамин цэргийн зан ширүүсч, дарлал зовлонд нэрвэгдсэн ардууд тэмцэж босох, энэ тэр гээд явдалтай л байх шиг байна гэж товчхон хариулна. Тэгэхэд цаадуул нь:

- Ай хайрхан! Цаг төр л тайван байгаасай билээ дээ Очирваань минь. Нуур амар бол нугас амар гэж, төр улсын байдал төвшин сайхан бол түмэн олон бид ч айх аюул багатай байх сан даа гэж наманчилгаана. Энэ мэтээр яриа хөөрөө үргэлжилж, гал дээрээс хонин тогоо ховхрохгүй байсаар үдэш болмоо.

Үдэш Сэргэлэн гуай, Даваа гуай, Өлзийхутаг, Өндөр Дэмчиг бас Молом гэж нэг жаахан долигонуур зантай боловч муу ядуу хүн зэрэг аавын дотно найз нар манайд уван цуван ирж морь унаагаа өвслөөд нэг л тохилог суугаалаа. Тэд үнгэгдэж муудсан “Үүчүүр” дэлгэж, түүнээ хүрээлэн суугаад тоглож эхлэв. Аав минь намайг дуудаж толгойг минь илж, үнсээд:

- Аавын хүү одоо унт. Аавыгаа шөнө дуудвал сэргэж цай халааж өгнө шүү гэхэд ээж хажуугаас нь:

- Миний хүүгийн аав нь ирсэн. Өнөө шөнө ч огт зүүдлэлгүй унтана даа гэнэ.

Би унтах дургүй, тэдний яриаг дуулах сан гэж хэчнээн хүсч байсан ч аав ээжийнхээ үгэнд орж хэвтээд удалгүй дээлээ толгой дээгүүрээ нөмөрч худлаа хурхирав. Тэгтэл ч тэдний яриа эхэллээ.

- Цаг төрийн байдал горьгүй байна. Ардын намынхны ажил үйлс ер нь өөдрөг байгаа. Саяхан анхныхаа хурлыг хийж намаа байгуулаад даргаар нь Сүхбаатарыг сонгосон гэж аав яриагаа эхэлснээ:



← Нөгөөс
ирсэн
захигал.

- Манай энд ямархуу байна даа, Сэргэлэн гуай? гэв. Сэргэлэн гуай модон соруултай данхар гуулин гаансандаа аавын авч ирсэн дүнсэн тамхинаас нэрж, тулганы галаас бараг бөхийлгүй асааж, хэд сорж утаагийг нь хамрынхаа хоёр нүхээр зэрэг олгойдууллаа. Тэгээд нэлээн дуугүй сууснаа:

- Энд ч яахав дээ. Саяхан манай ноёны шинэ алба гарсан. Айл бүрээс таван лан татаж байна. Нөгөө л “Дашин Кү”-гийн пүүсэнд дахиад өртэй болсон юм байх. Манай муу Буяндогоо татвар төлөх хөрөнгөгүй гээд тамгын очсон. Ийм л янзтай ертөнцийн хоног хороож байх юм даа гэхэд Молом гуай,

- Амьдрахад ядуу бидэнд хэцүү л байна гэж хэлэв.

- Чи ардын намын тэр хуралд суусан уу? гэж Сэргэлэн асуув.

- Үгүй. Харин шийдвэрийг нь биелүүлэх үүрэг л бид бүхэнд оногдоод байна гэж аав хэлэв. Молом гуай урагш давшлан “үүхай” гээд аавд дөхөж суув.

- Тэгвэл чи минь бараг тэр хэргээр ирсэн болох нь уу?

- Яаж мэдэх вэ. Эр хүн өөрийнхөө зорилгын төлөө яг л бууны сум шиг байх хэрэгтэй. Хэрэв тэгээд онох хэрэг зайлшгүй тохиолдвол онох л хэрэгтэй юм шүү гэж манай Сүхбаатар хэлдэг юм. Найз чинь цэрэгт очоод газар дээр ганц найзтай болсон. Энэ яриад байгаа Сүхбаатар шүү дээ гэж аав хэлээд, дөрвөн чихтэй эсгий тооригоо ээжээр авахуулаад дотогш нь нугалж хэвшүүлсэн том чихийг нь ханзлав. Тэр дотроос нэг л их нандин юм гаргах нь гэж бодоод би золтой л ухасхийчихсэнгүй. Гэвч тэр бичгийг би лав сайн харсан юм. Ам дөрвөлжин цаастай тодоос тод бичгийг аав Сэргэлэн гуайд өглөө. Сэргэлэн гуай нөхдөө ажигласнаа:

- За чимээгүй. Бүгд сонсогтун! гэв.

Найзууд нь хэдийгээр бичгийн үсгийг ялгахгүй ч гэсэн цөм л унших гэсэн юм шиг үгэнд дурлан тонгойцгоов. Чив чимээгүй болов. Гэтэл Даваа гуай бараг шивнэх шахам дуугаар,

- Та минь, гай газар дороос гахай модон дотроос гэж гэв гэнэт хүн хүрээд ирэх вий дээ! гэвэл аав толгой дохиод,

- Манай хоёр нохой юу ч гэсэн саахалтын газар явахад нь дохио өгнө гэв. Тэгээд Сэргэлэн гуай,

- Та нар бүгдээрэ сайн сонсогтун! гэж анхааруулаад, нөгөө бичгийг нам дуугаар боловч аялгуулан уншсан нь:

“МОНГОЛ АРДЫН НАМААС ТҮМЭНД ТУНХАГЛАН ЗАРЛАХ БИЧИГ”

Манай монгол үндэсний олон аймаг эрт урьд цагаас нааш бусад улсуудын албат боол болж дарлагдан, гашуун зовлонг амссан удаа олон буй авч бас харгис этгээдийн савраас гарч, өөрийнхөө газар орон, ёс суртлаа мандуулан өөрөө эзэрхэн эрх биш өөрийн улсыг байгуулдаг түүхтэй... гэх мэтээр уншаад хамгийн сүүлд онцлон тодоос тод,

“...Энэхүү арван зүйлийг бичээд хотолд тунхаглан зарлав. Улам улам тараагтун!” гэж уншиж дуусгав. Шөнө дөл болсон хойно хүмүүс тарлаа.

- За нөхөд минь, энэ тунхгийг түргэн, болгоомжтой тараах хэрэгтэй шүү. Хэрэв... гэж аав ямар нэгэн юм шивнэн хэлсний нь би дуулж чадсангүй. Хүмүүсийг явсан хойно, аав ээж хоёр намайг сэрүүн байгааг мэдээд бие бие үрүүгээ харснаа:

- Чи ч одоо болтол унтаагүй байгаа юм уу? Бидний яриа хөөрөөг бүгдийг сонсов уу? гэж асуув.

- Сонссоон, гэж би үнэнээ хэллээ.

- Энэ бол “аюултай” бичиг хүү минь! гэж аав үгээ онцлон:

- Гэхдээ энэ бичгийг өвөртөлж яваа хэн боловч өөрийгөө аз жаргал байлдан олохын төлөө явж байгаа хамгийн үнэт хүн гэж бодох хэрэгтэй. Алдаж осолдвол толгой цустах аюул бий гээд тэр бичгийн тухай хэзээ ч, хэдийд ч, хэнд ч хэлж болохгүй, хэрэв хэлэх юм бол манай ганцхан гал голомт балрах төдийгүй өдий төдий гэмгүй шударга ардын үйл хэрэг баларна гэдгийг ярьж ойлгууллаа. Ийнхүү би аавтайгаа чухал юм зөвлөсөндөө баярлан,

- Хэзээ ч, хэдийд ч би энэ хэргийг задруулан ярихгүй гэсэнд аав ээж хоёр инээлдэв. Ээж:
- Миний ухаантай сайн хүү одоо унт. Маргааш их ажилтай гээд намайг үнсэв.

Сэргэлэн

Энэ өдрөөс хойш тун ч удалгүй манай аавыг хошуу тамгынхан сэжиглэн хардах болов. Өнөө бичгийг хүн болгон бие биедээ дамжуулан байсан болохоор хэн үүнийг анх тараав гэдгийг олох гэсэн л байх.

Нэлээд хэдэн хоног өнгөрч, аавын бие овоо болоод хааяа гарч үзнэ. Шөнө өдрөөр ганц нэг хүн ирээд, манай аавтай ярьж ажил хэрэг зөвлөнө.

Нэг өдөр аав хэлсэн нь:

- Аав нь удахгүй явна.
- Хаашаа? гэж би цочин асуусанд,
- Хол, их хол явна. Одоо чи сайн ойлгох хэрэгтэй. Миний очих гэж байгаа тэр газар, олон хүн нэгдэн нийлж, жаргалын төлөө тэмцэж байна. Тэр бол хад ноёдтой нэгийгээ үзнэ гэсэн хэрэг. Чи ойлгох ёстой. Биднийг дайсан мэдсэн шиг байна. Бидний дунд итгэл муутай улс байгаа шиг санагдана. Тэд нар “Урвасан хулгай нару гэж биднийг нэрлэж байна. Хэн нь хулгайч нар болохыг одоо удахгүй чи заалгах болно гэлээ.

Хоног гэдэг харвасан сум адил хурдан өнгөрч, зуны дунд сар гарлаа. Хүрээнээс ардын намынхны тухай сураг улам дэлгэрэн тарах болж, өвгөд буурал сахлаа илбэн дув дуугүй сууцгааж, дотроо нэгийг бодоцгооно. Би өдрийн цагаар ээждээ туслахын хамт аргал ус бэлтгэж, аавтайгаа бараг өдөржин ярина.

Тэр нэг орой гайхал төрмөөр нам гүм байлаа. Аав намайг өөр үрүүгээ татан, чихэнд минь ингэж шивнэлээ.

- Төрөө чи сонсооч! Би чамд одоо нэг бичгийг цээжлүүлье. Чи үүнийг цээжлэх ёстой. Үүнийг зүгээр нэг цээжлээд ч бас зогсож болохгүй. Малчин ардуудад, түмэн олонд чи таниулах ёстой. Энэ бол их үйл хэрэгт ард түмнийг уриалан дуудсан бичиг байгаа юм гээд өнөөх бичгийг гарган ирэв. Би түнийг сайн таньж байна.

- Би тэр бичгийн чинь учрыг мэднэ гэсэнд аав над уруу хараад:

- Уухай, юу гэсэн бичиг гэж чи ойлгоов? гэсэнд,

- Тэр бичиг үү? Тэр бол муу сайн лам ноёдыг хааш нь ч юм хөөгөөд, ядуу ардууд жаргана гэсэн юм билээ гэлээ.

Аав миний хэлснийг анхааралтай сонсч аваад өхөөрдсөн янзтай нүдээ гялалзуулан инээмсэглэв. Ингэхлээрээ аав заавал ёжтой үг хэлдгийг би мэднэ.

- Дайснуудыг хөөнө гэдгийг чи зүгээр нэг хонь элдэхтэй адил юм бодоогүй биз гэж аав инээлээ.

Эд нар чинь тийм амархан хөөгдөх улс биш шүү дээ. Малчин ардууд эв санаагаа нэгтгээд зангидсан гар шиг хүчээ хамтатгах юм бол сая тэднийг дийлнэ. Тэгэхийн тулд яах хэрэгтэй вэ? Энэ уриаг унших хэрэгтэй. Олон хүнд, түм түмэн малчдад унших хэрэгтэй. Тэгвэл тэд учрыг ойлгож мэднэ. Мэдэв үү? гэв.

- Ойлголоо! гэж би өгүүлээд,

- За тэгвэл цээжилж эхэлье гэсэнд аав сайшаан толгой дохиод, өнөөх бичгийг хоёр гардан авч уншив. Тэр өдрөөс эхлэн бид хоёр түүнийг цээжилж эхэлсэн юм. Энэ явдал миний залхууг хүргээгүй, харин ч баяртай сайхан санагдаж байв.

“За үүнийг би аав шигээ олон хүнд уншиж таниулна. Бүгдээр нам жим сууцгааж миний хэлэх үгийг сонсох биз. Тэгэхийн хамт бас үүний учрыг дорхноо ойлгоод манай талд орох ч юм билүү. Баахан ах нарыг элсүүлээд, тэр долир Долойгоос авахуулаад энэ муусайн дайснуудыг цөмийг хүйс тэмтрэн устгана даа” гэж бодно.

Удаан хүлээсэнгүй, шалгах өдөр болж аав намайг өмнөө номхон зогсоогоод,

- За унш! гэж хэлэв. Би торж түгдрэлгүйгээр хангинатал уншсанд аав баярлан, гарыг минь атгаад:

- Миний хүү их сайн байна. Одоо чи үүнийг зөвхөн аавдаа биш, хүмүүст унших болно. Миний нөхөд чамд тусална гэлээ.

Бид хоёрын яриа дөнгөж дуусч байтал гадаа морин туурай тачигнаад, нэг хүн ирж буув. Би хэн болохыг харах гэж гүйн гарахад ээж миний хойноос гарлаа. Манай гэрийн хаяанд Сэргэлэн ах мориноосоо бууж байв. Сэргэлэн ах миний аавын багын найз юм. Анчин хүн тул гол төлөв ой хөвчөөр нутаглана. Аав бид хоёр

түүнийг дагаад анд явж байсан удаа ч олон. Тэр морио тушин, гэрт гүйж ороод, шууд аав уруу очиж амьсгаадан сандарч өгүүлсэн нь:

- Содов оо! Содов минь, босч үз! Зугтаа, одоохон зугтаа! Цаана чинь хошуу тамгынхан чамайг барих гэж байна. Өнөө шөнө бүрэнхийгээр ирж чамайг бариад бусдыг чинь бас барих гэж байгаа гэнэ. Сэтгэл зүрх нэгтэйгээрээ Дорлиг галч хошуунаас над уруу хэл өгч явуулжээ. Яв, яв! гэв. Энэ үгийг сонсоод миний дотор эвгүй болж, хайрт ааваасаа ахиад л хагацах нь гэж хоолой минь зангиран, нулимс нүдийг бүрхээд ирлээ. Аав царай нь барайн үсрэн босоод хөлөө хөндсөнөө ч анзааралгүй хувцаслаж эхлэхэд ээж ч мэгшин уйлж, хувцас хунарыг нь төхөөрөв. Аав хувцсаа өмсч байх хооронд би морий нь авчирч эмээллээ. Аав мориндоо мордоод хэлсэн нь:

- Миний хүү, энэ ахыгаа цаг ямагт дагаж яв. Сэргэлэн, би чамд хүүгээ захия. Түүнийг хатан зоригоор хүмүүжүүлж, намаасаа өгсөн даалгаврыг биелүүлэх ёстой.

- Мэдлээ! гэж Сэргэлэн ах аяархан шивнэнэ. Ээжийн гарыг атгаад, аав:

- Зоригтой бай, Насаан. Битгий сандар! Өнөөдөр ингээд явав ч эргэж ирэх өдөр тохиолдоно. Миний хүү, ахынхаа үгийг сайн биелүүлж бай! Чамд түүнээс өөр зорилго үгүй гээд бөхийн духан дээр минь үнсээд довтолгон одлоо.

Аав явж одсон боловч, түүний үүсгэсэн их үйл хэргийг биелүүлэх үүрэг надад оногджээ гэдгийг би сүүлд нь ойлгож авсан билээ. Тэр үдэш манайхаар бөөн улс ирээд, гэр барааг онгичин нүцгэн унтаж байсан миний хучлагыг хуу татан босгов. Долой гуай, уурга шиг урт хар буугаа нохой алах гэж байгаа юм шиг шагайсан орж ирэх нь хорсолтой. Тэр ээжийн урд бууныхаа гол төмрөөр хамрыг нь сөргөөж асуусан нь:

- Муу шулам, чи хэл! Чиний урвасан хулгай хайчсан бэ?

- Би яаж мэдэх юм бэ гэж ээж ер айсан шинжгүй, хээв нэг хариулсанд Долой уурлан хашгирсан нь:

- Яаж мэдэх вэ гэнэ ээ, улааны муу шулам. Чамайг би мэддэг болгоно доо гээд ээжийг барьж байсан хоёр хүн үрүү,

- Аваад яв наадхаа. Энэ гэрийг шатаа, тэр хүүхдийг хөөж гарга!

Голомтныхоо шатсан үнсэн дээр тэгээд та нар төрийн хэргийг

хэлэлцэж, түмний толгойг эргүүлж бай гээд гарав. Нэгэн хуяг ээжийг минь чирэн гарахад би ээжийнхээ хормойноос зүүгдэн орилж:

- Ээжийг минь тавиач гэж гуйсанд хуяг, намайг өрөвдөн ээжийг минь тавихын оронд, майжгий ултай тэмээн таваг шиг хүнд хөлөөрөө элэг үрүү минь өшиглөв. Тэгээд би ухаан алджээ. Ээж минь миний зүг тэмүүлэн, хуяг нартай ноцолдсон боловч аргагүй дийлдэн явсныг би хожим сонссон билээ.

Нэг л мэдэхэд би шатсан гэрийн буурины дэргэд ухаан алдчихсан хэвтэж байв. Шөнийн нүхэн харанхуй намайг нөмрөн, одод гасланг минь хуваалцаж, хөөрхий балчир намайг өрөвдөж байх мэт анивалзана. Талын салхи ээжийн минь оронд намайг үнсэн, сэрүүн амьсгаагаараа толгойг минь сэргээж,

- Төрөө чи бос! Чи баатар зоригт эггийн үр шүү дээ. Балчир жаахан ч гэсэн чи дайснаас өшөөгөө авах ёстой гэж хэлж байх мэт санагдана.

Би хөндүүрлэсэн элгээ дарсаар босов. Дөнгөж босоход минь миний ард ямар нэгэн морин туурай тачигнахад би эргэн хараад ум хумгүй зугтав. Миний ард сарны сэрүүн цагаан гэрэлд цав цагаан морьтой хүн зогсож байсан билээ.

- Төрөө, Төрөө! гэж намайг дуудна.

Хэний дуу болохыг таньсангүй, танихыг ч хүссэнгүй. Нүдэнд минь зальт дүрс болон үлдсэн өнөөх муухай долир Долой мөн мэт санагдаад түүний гарт үхэхгүй тулд, хүч мэдэн гүйсэн билээ. Өнөөх хүн миний араас мориор хөөнө...

- Битгий ай! Ээ чааваас гэж дээ, би Сэргэлэн ах чинь байна. Битгий ай, ах нь байна гэж тэр миний хойноос хашгирсаар байхад би "Намайг хуурах гэж байна. Яасан ч би түүний гарт орохгүй дээ" гэж бодоод улам улам хурдан гүйсээр байхад, өнөөх хүн цөхрөнгөө барсан бололтой, миний хойноос морио гуядан хөөж инээд алдан, дээлнээс минь шүүрэн авч эмээл дээрээ авав.

Миний аав

- Аав тэгээд хайчсан бэ?

Сэргэлэн ах түүнийг Өгөөмөрийн өвөлжөө хүртэл үдэж өгчээ. Хугарсан яс нь бороолж гүйцээгүй аав минь Сэргэлэн ахын мөрийг хэсэг түшиж зогсоод,

- Одоо чи буц! Би цааш явна. Надад битгий сэтгэлээ зов гэж захижээ. Аавын урдаас удал ширтэн зогсож, дотроо “Яаж шүү нөхөд дээрээ очно доо, энэ хүн” гэж бодоод Сэргэлэн ах хэлсэн нь:

- Чамайг ганцаарангий чинь явуулахад хүнд байна. Гэвч яая гэхэв. Энд ажил төрөл их байна шүү. Одоо чи буц гэж аав хэлээд явчихсан гэдэг юм. Сэргэлэн ах далд ортол нь нүдээрээ үдэн зогсчээ.

Энэ өдрөөс эхлэн хошууны тамгын газар хөлтэй болж, аавыг уул хадаар эрэн хайж морьтой улс давхилдах боллоо.

Гурав дахь өдөр аав өнөөх эрэлчидтэй Цуурайтын дээд эхэнд санамсаргүй дайралджээ. Уул хэрэг ингэж үүссэн байв. Тэр барзгар хадтай уулын урд энгэрийн хөсгийн замаар аавыг мориныхоо амыг татсаар аажуухан гэлдэрч явтал гэнэт урдаас нь дөрөв таван морьтой хүн давхин иржээ. Аав тэднийг хармагц морио эргүүлэн Цуурайтын баруун суга өөд мориныхоо эцсийн хурдаар хурдлан зугтав.

Буун дуун исгэрнэ. Хадан цохио оносон сум толгой дээгүүр улин шуугьж сэтгэл зүрхийг өвтгөнө. Мөрдөгчид түүнийг их ойд оруулахгүйсэн гэсэн байдалтай хашгиралдан бүслэн авахаар тойрон ирэв. Аавын морь түүнийг их ой уруу улам улам түргэн аваачив. Дайснуудыг саахалтын хэрд байхад аав, гүн ой уруу ороод алга болжээ. Даваан дээр гарч ирсэн Долой өтгөн ой уруу ширтэн харж, хорссондоо уйлах шахаад, цаадуулдаа л уураа гаргаж,

- Алдчихлаа, хайран юм алдчихлаа. Ээ, бас тоогүй, тун тусгүй гэж амаа барьжээ. Усан хулгана боллоо хөлөрсөн морьд амьсгаадан зогсоно. Цуурайтын ой бас ч тийм их ой биш тул Долойн санаанд орсон нь: “Энэ ойг бүхэлд нь бүсэлж хаах

хэрэгтэй. Хэд хоногийн турш бүслэн хаахад энэ муу, ойгоос гарахгүй хаачих вэ” гэж боджээ. Тэгээд тэр хөмсгөө зангидан Очир гэгч нэгэн этгээдийг дуудаад,

- Тамгын газар оч, хүн ол! Цөмийг авчир. Ойг бүслэнэ гэж тушаав. Долой ой уруу орохоос айх тул хяр дамжин сажлуулахаар мориныхоо амыг татав.

Долой хэлсэндээ хүрчээ. Тэд ойг битүү бүслэн, ойн гүн үрүү буу ничигнүүлэн нөмрөв. Удаан хүлээсэнгүй оройхон хэр аавын унаж явсан морь, цулбуураа чирсээр ойгоос гарч иржээ. Долойнхон морийг талын зүг хөөсөөр барьж авчээ. Морины хөл шалбарч, эмээл нь цустай байв. Аавын тухай хүмүүс муу юм бодоцгооно. Эзнээ орхиод гарч ирсэн энэ хэл мэдэхгүй адгуусаас ямар асуултай биш дээ.

Ууландбайсан хүмүүс түүний хойноос алмайран ширтэцгээнэ. Долой бах тав нь ханасан нүдээр морийг хараад,

- Содов, миний суманд оногджээ. Тэгэх л ёстой. Миний хэрэг бүтлээ. Та нар энэ эмээлийн цусыг хүний цус биш гэж баталж чадах уу? Миний бас нэг олсон юм энэ гээд нэгэн нойтон малгайг өврөөсөө гаргаж ирлээ. Тэр бол аавын өмсөж явсан цэнхэр малгай байв.

- Цуурайтын ойгоос эх авсан Жаргалантын голоос үүнийг олсон юм. Миний бодлоор бол Содов шархдаад бидэнд баригдахгүй гэж энэ голд унаж үхсэн байж таарна гээд,

- Урвасан хулгайч далд орсон тул одоо таригаа. Энэ морь өнөөдрөөс эхлэн, миний дансанд орно гээд эргэв. Сэргэлэн ах энэ хүнд эгшинг нүдээрээ үзсэн тул,

- Үнэн үү, нээрээ өнгөрсөн гэж үү? Содов маань өнгөрлөө... гэж амандаа шивнэн нулимс унагаж байжээ. Аавын сураг ийнхүү тасрав.

Цуурайтын их ойн аль жалганд миний аавын алтан сайхан цогцос байгааг би тэрхэн үед олох гэсэн мэт, үргэлжлэн цэнхэртэх ойг ширтэж, балчир бага насны гэнэн зангаар нулимс унагадаг сан. Харин аавын нөхөд Цуурайтын ойг самнан эрээд, хаанаас ч аавыг олсонгүй. Зун цагийн багсайн ургасан их навчис шилмүүс дотроос яаж ч олох билээ дээ...

Балар ойн анчин

Та нар намайг тэр шөнө хэний гарт орсон гэж бодож байна. Би та нарт өөрийнхөө тухай тодорхой хэлж өгнө. Маш их айснаас ч тэгсэн юм уу, эсхүл өвчин туссан юм уу, би ахиад л ухаан алдчихжээ. Нэг сэрэхэд, би ээжтэйгээ хамт хар модон урцанд хэвтэж байв. Юу болсныг санах гэж оролдож үзлээ. Энэ ерөөсөө зүүд байх гэж эргэлзэж эхлэв.

Ээж минь миний хучаастай хөлийг гараараа барьж үзээд, “Халуунгүй байна” гэх шиг нэг юм хэлснээ инээмсэглэн намайг ширтэв. Овоохой шиг юмны хананы зай завсраар зуны нар тусна. Ухаан санаа минь саруулхан болов. Тэгэвч болж байгаа зүйлд итгэж өгөхгүй байлаа. Гадаа улсууд шуугилдаад ч байх шиг. Би нүдээ нээж, томоор хараад ээжийгээ яг дүрээрээ сууж байхыг ажиглан,

- Ээж ээ! гэж баярлан дуудвал, ээж намайг тэврэн авч үнсээд,

- Чимээгүй гэж дохив.

- Ээж ээ та ирээ юу? гэхэд минь,

- Ирсэн ирсэн, миний хүү гэж ээж хэлээд,

- Дуугүй бай, гадаа хурал болж байна. Чи хаана ирээд байгаагаа мэдэж байна уу? Бид чинь Өлзийтийн дээд эхний модон дотор, анчингуудын урцанд байна шүү дээ гэлээ.

Тэр өдөртөө бүрэн сэхэж, босч гадагш гүйн гарахад минь ой доторх модон урцны өмнө Сэргэлэн ах, аавын нөхөд харагдахад нь хэчнээн их баярласныг яана!

- Яагаад би долир Долойд баригдчихаагүй ирсэн юм бол гэж би гайхлаа.

Эцэст нь би баясгалантайгаар,

- Ээ, энд аавын нөхөд, энд... мөн сайхан аа гэж бодов. Хүмүүс модны сүүдэрт суугаан нэгэн чухал зүйл төлөвлөж ярилцана. Тэдний ярианаас, “Байлдах, үлдэн хөөх, ухуулах” гэдэг үгс тодоос тод сонсогдож байв. Намайг хараад Сэргэлэн ах:

- Үгүй ер өө? Төрөө хүү босоод ирж, нааш ир гээд,

- За миний дүү, нөгөө бичгээ нэг уншаад орхи гэсэнд би ч цээжилсэн үгээ санан, дуржгинатал уншив.

- Сайн байна.

- Ойтой хүү.

- Ажилдаа орох нь болж... гэлцэнэ.

Ажилд орно гэсэн нь юу гэсэн үг вэ гэж би бодоод бодоод учрыг олсонгүй. Сэргэлэн ах хэлсэн нь:

- Маргаашнаас эхлээд хоёул дандаа ойд нуугдахгүй шүү. Гадуур явна, ажил хийнэ. Харин ээж нь ах нартай нь хамт үлдэнэ гэсэнд:

- Ээжийг яаж аварсан бэ? гэж би зориглоод асууж орхив. Сэргэлэн ах хэсэг байснаа шанаагаа илж:

- Ах нар нь уу, ах нар нь долир Долойгийн тэр хүн түгждэг хар гэрийг, танай гэрийг шатаасантай нь адилхан үнс болгож орхисон юм. Одоо тэр бид нарыг эрсээр байгаа боловч энэ шилмүүст ойгоос эгээ л тэр муу олдог нь юу бол доо гэж инээсэнд:

- Диваажингийн даамал болсон хойно, нисдэг мориор ойн дээрээс харж магадгүй гэж нөгөө нэг ах хэлээд хүд хүд инээв.

Ээжийг тэд оргуулж аваад, хорьж байсан гэрийг нь шатаажээ гэдгийг би ойлгов. Ээж минь нэг л уруу дорой сууна. Намайг удаан ширтэхийн хамт, түүний том алаг нүд гунигтай байх шиг санагдана. Хоол идсэний дараа би түүнээс:

- Ээж ээ та яагаа вэ? гэсэнд ээж:

- Зүгээр хүү минь, толгой өвдөөд гэснээ,

- Аавынх нь морийг Долой унаж явна гэнэ гэв.

- Худалдсан юм уу?

- Хаанаас даа...

- Булаасан юм уу?

- Үгүй байх аа...

- Тэгээд... гэхэд минь ээж намайг элгэндээ тэврээд,

- Ишш, хүү минь хүү минь! Муу аав чинь сайн л явдаг байгаа даа, хөөрхий гээд үйлж орхив. Ээжийгээ би өрөвдөж дагаж үйлмаар санагдсан авч, аав намайг томоо эр хүн гэж хэлснийг бодоод ээжээ тайтгаруулж,

- Зүгээр ээ, ээж ээ. Аавыг барагтай дайсан дийлэхгүй. Тэр чинь хүн аймаар том буутай хүн шүү дээ гэсэнд ээж:

- Томоогүй амьтан гээд намайг үнсэв.

Энэ өдрөөс эхлэн би аавынхаа даалгаврыг биелүүлж, айл хотлоор яриа хийх боллоо. Намайг цаг ямагт бэлтгүүлж дахин дахин уншуулсны дараа Сэргэлэн ах:

- За, доод Бүрдэн дээр Гомбынд очиж уншихаад ир гэх юм уу, үгүй бол баян Лодойн адууны бэлчээр дээр оч. Даваагийнхаар ороод, орой ирээрэй гэх мэтээр даалгаж явуулна. Намайг очиход аавын хэн нэг танил нь угтаж авч, цугласан улс дээр очоод,

- За унш гэж шивнэнэ.

“Манай Монгол газар бүрийн олон хошуу, шавийн ард түшмэд санал нэгдээд, чин үнэнхүү зоригоор манай монгол үндэсний олон амьтан, уул газр усаа эзлэн түмэн ардын зовлон жаргалангийн аливаа явдлыг цөм бүгдээр зөвшөөрөн шийтгэж, хүмүүжин боловсрох их замыг нээж өгсөн төрөө дахин шинэчлэн босгож, тасарсныг залган, хэмхэрснийг эвлүүлэх их үйлсэд нь амь бие, эд зоорио огоортол зүтгэсүгэй гэж бат журмаар барилдан Монгол Ардын Нам байгуулж, тус намын эрмэлзэх зүйлүүдийг манай монгол үндэсний түмэн ардад мэдэгдэн зарлах нь” гэж намайг эхлэн уншихад хүмүүс улам сонирхож, ахин дахин уншуулан, “Мэдлээ” гэсэн мэт толгой дохин, дараа нь нам дуугаар зөвлөлдөжгөөнө. Хүмүүсийн юу боддогийг би сайн таахгүй боловч энэ бичгийг уншихын хамт л хүссэн хүслээ биелүүлж, ханаж цадаж байгаа мэт инээмсэглэцгээдэг байлаа.

Анхандаа би бичгийнхээ утга учрыг ойлгодоггүй, цээжээр уншихаад л давхиад явчихдаг байсан боловч сүүл сүүлдээ тунхгийн үг үсэг надад улам ойлгомжтой болоод, жаахан тайлбарладаг болов. Ойгоос анд явж байгаа Сэргэлэн ах бид хоёрыг дайснууд огтхон ч сэжиглэхгүй. Харин өнчин ядуу хүү намайг өөрийн ивээлдээ авсан Сэргэлэн ахыг гайхан хараад л өнгөрөөдөг байв.

Тэр жилийн зуны адаг сард би арван гурван нас хүрэв. Намын тунхаг бичгийг хүн болгонд уншсаар түүний уриа нь нутаг даяар түгж, манай жижигхэн бүлэгт бүүр алс хошуунаас хүртэл хүмүүс ирж элсэх болов.

Сэргэлэн ах бид хоёр гөрөөс намнах нэрийдлээр хошуу нутгаасаа алс гараад хэд хоногоор явна. Ах надад олон юм ярьж өгнө.

- Төрөө, одоо чи бичиг сур, гэж нэг өдөр надад хэлсэн нь намайг их баярлуулав. Тэгээд бид хоёр ойд өдөр бүр тогтмол сууж, монгол бичиг заалгаж, бичиг ном үзэх болов. Биднийг дайсан эрж байгаа чимээ өдөр болгон сонсогдоно. Сэргэлэн ах бичгээ заасаар л байв.

Нэгэн өдөр Сэргэлэн ах намайг айсан юм шиг, ийш тийш харж байхад:

- Битгий ай, чиний аав зоригтой хүн байсан юм гээд нүүр нь жаахан улайсхийж,

- Миний дүү, чи нээрээ аавынхаа тухай сонсоогүй билүү гэв.

- Аавыг чинь дайснууд аягүй бол үгүй хийсэн байх. Тэр нэг өдөр цустай эмээлтэй морь давхин ирснээс хойш би түүнийг амьд мэнд яваа гэж итгэхээ байсан. Муу сайн дайснууд та нараас би өшөөгөө авч чадна даа, харж байгаарай гэж Сэргэлэн ах хэлэв. Энэ үгийг сонсоод би тэссэнгүй,

- Яана гэнэ ээ, гээд нулимс нүд бүрхсэн тул би юу ч харж чадсангүй.

Аав минь дайсанд хорлогдсон юм бий! Тэгээд ээж минь уруу дорой байсан юм байж гэж би одоо л ойлгоод бичгээ ч бичиж чадсангүй.

- Хайрт аав минь. Үүсгэсэн хэрэг нь хаврын яргүй адил дэлгэрэн тархаж байна. Анхандаа уулын горхи адил жирэлзэн гарч ирсэн ганц хоёр хүний бодол санаа нь одоо их мөрөн мэт бялхан, үй олон хүний сэтгэл зүрхний үер болж, тэднийг тэмцэлд дуудан байгааг хайрт аав минь үзээсэй гэж би хэчнээн их хүсдэг билээ. Аав минь, аав минь гэж амандаа шивнэн суув. Сэргэлэн ах миний мөрөн дээр гараа тавиад,

- Хүү минь, зоригтой, хатуужилтай бай! Чи эигийнхээ зүрх зоригийг уламжлан авч дайсны үнэн мөнийг ард түмэндээ итгүүл, мэдэгд, зоригтой бай гэж аргадаж билээ. Хөвч тайгын анчин хүү идэр зоригтой Сэргэлэн ахынхаа заасан үсэг бичигт амархан суралцаад, одоо бидний итгэл болсон тэр бичгийг цээжээр биш нүдээр харан уншиж таниулах боллоо.

Урвагч

Бараг бүх хүн тараад, гадуур ажил төрөл хөөцөлдсөн өдөр байв. Ээж тэгэхэд бас юманд явчихсан, харин Сэргэлэн ах бид хоёр, бас хэдэн хүн овоохойдоо үлдсэн байлаа. Гадаа хөлийн чимээ гарч Молом гуай орж ирэв. Тэр хэд хоногийн өмнө яваад, удтал алга болоод ирж байгаа нь энэ. Баруун хошуунд байдаг

нагац ахын бие өвчтэй. Нас өндөр болсон тул ирж уулз гэж хэлүүлсэн байлаа.

- Сайн явав уу, Молоом? гэж Сэргэлэн ах түүний зүг эелдгээр асуув. Тэр хүн хонин бор нүдээрээ гунигтайгаар ширтэж, уужмаар санаа алдаад,

- Өнгөрчихлөө, Ах минь өнгөрчихлөө гэж шивнэв. Хүн бүр сэтгэл зовиуртай, түүний зовлон гасланг өөрийн биеэр эдлэв. Тэр чичирхийлсэн хоолойгоор хэлэх нь:

- Газар дээр ганц харах ах минь байсан юм сан. Тэр минь намайг орхиод алга болов. Жанцан ламын хаяа түшиж малыг нь маллаж, аргалыг нь түүж яваа аз жаргалтай хүн гэж би хэчнээн их итгэдэг байлаа. Тэгээд, ганц бие ахыг минь зарж зарж, эцэст нь өвчин тусахад хумсын чинээ тус ч үзүүлсэн юмгүй хар нутаг дээрээ хаяад нүүдэг байжээ. Энэ муу сайн нүгэлт амьтад хэзээ арилж үгүй болох юм бэ? Ард хүн хэзээ нуруугаа тэнийлгэх юм бэ гээд уйлж орхив. Бид түүнийг тойрон суугаад элдвээр аргадах гэж ядлаа. Сэргэлэн хорссон мэт ярвайж, уурандаа цээж оволзуулан хэлсэн нь:

- Битгий уйл, Молоом. Ялалт манайд ирнэ. Эр хүн шиг нугаршгүй хатан зоригтой бай. Чиний өшөөг авах цаг ирнэ гэсэнд гадаа хэн нэгэн хүн:

- Худал, шал худал! Чи одоо урвасныхаа төлөө бори болно вий гэх Долойн дуу дуулдаж,

- Та нар бүү хөдөл, нэгэнт бүслэгдсэн! Үг дуугүй бууж өгвөл төдий сайн гээд овоохойн хучаас шилмүүсүүдийг тал тал уруу нь буулгаж эхлэв. Бууны ам тэндээс ёрдойно. Сэргэлэн ах нэгийгээ үзэхээр гүйн гарахад хэдэн хүн түүнийг барин авч тэр дорхон нь хүлэв. Бидний зүг тэд дайран ирж, надаас бусдыг нь цөмийг барьж хүлээд, Долой хэлсэн нь:

- Цөмийг аваад яв! Ойн дээрэмчин Сэргэлэн чи одоо эгээ өшөөгөө авна гэж наргихгүй биз гэв. Энэ завсар Сэргэлэн ах над уруу харж ойруу дохисонд “Зугтаа!” гэсэн үг гэж би ойлгоод модны мөчир доогуур шурган алга болов. Миний ард буун дуу нүргэллээ. Тэд миний хойноос хөөсөнгүй бололтой. Гэвч би уйлж байв.

- Хөөрхий, Сэргэлэн ах минь. Түүнийг лав дайснууд хөнөөх биз. Яаж чөлөөлөх билээ? гэж би амандаа шивнэж явлаа. Урд шөнийн борооны ус хатаагүй байсан тул ойн ногоо шал нойтон.

Бас мөчир хөдөлгөх төдийд модны ус нуруу руу минь цацална.
Нил ногоон өнгөөр гэрэлтэн үзэгдэх ой, бүхнийг ногоон туяагаар
гэрэлтүүлж, газар ус, тэнгэр ч ногоон болчихсон мэт санагдана.
Би ой дотор хээр хоноод өглөө нь ээжийн очсон айлд хүрэв.
Настай авгай намайг дуу алдан угтаж,

- Эвий минь, хаанаас ирэв? Хөөрхий минь гэж өрөвдөн
хайрлав. Би ойгоос ирснээ хэллээ.

- Ээж чинь дөнгөж сая ой уруу явсан шүү дээ, хүү минь гэж
тэр эгчийн хэлсэнд цочин,

- Хэзээ? гэж дуу алдав.

- Дөнгөж сая. Чамайг авчрах гэж явсан даа, хөөрхий минь
гэв. Дайснууд тэнд тосоод байх юм шиг бодогдоод улам айн
сандрав. Тэгээд би бослоо.

- Чи хаачих нь вэ? гэж авгай том харж гайхсанд:

- Ой уруу ээжийн хойноос очино гээд би:

- Танайд морь байна уу?

- Бий.

- Надад өгөөч. Би ээжийнхээ хойноос яарахгүй бол болохгүй
нь.

- Хүү минь, ээж чинь одоо ирнэ.

- Үгүй, та надад морь л аль.

Ийнхүү ярилцан байх завсар сонсвол гадаа нэг хүн ирэх шиг.

Би ээжийг ч танилаа л даа.

- Ээж ээ, гээд гүйн гарахад, миний ээж гадаа зогсож байв.

- Хүү минь гэж намайг тэврэн үнсээд өнөөх авгай уруу:

- За, бид хоёр явахаас өөр замгүй боллоо. Та нар минь
баяртай! Ойд аюултай юм болжээ. Ойгоос намайг барихаар
хэдэн хүн хөөсөн боловч би өрсөөд тэднийг төөрүүлж дөнгөв.
Одоо бид хоёр зугтахсаас өөр мэх алга гэсэнд өнөөх авгай нэгэн
хүүдийд ааруул хурууд хийж өгөөд,

- Сайн яваарай гэж ерөөв.

Ээж намайг эмээл дээрээ суулгаад, өөрөө сундалж цааш
явлаа. Замдаа би ээжид ямар хэрэг болсон тухай ярьж, хэрхэн
Сэргэлэн ахын дохисноор зугтан гарснаа өгүүлсэнд ээж
бодлогошрон явснаа хэлсэн нь:

- Зугтаж гардаг чинь их сайн хэрэг. Харин бидний энд байгааг
хэн хэлж хошуу худалдав. Мэдэх үү? Чи санаж байна уу гэв. Ээж

минь нөхдийнхөө төлөө их санаа зовж байгаа бололтой,

- Зүгээр өнгөрөөх ёсгүй! Юуны өмнө хошуу худалдсан урвагчийг олох ёстой. Хэн бэ? гэж ээж амандаа шивнэн бодно.

- Үгүй, яасан ч бид хоёр хар амиа хөөн ингэж явж болохгүй. Бидний эгнээнд байгаа урвагчийн талаар нөхдөдөө хэл хүргэх, бас ч тэднийг суллахын тулд оролдоод үзэх хэрэгтэй гэж ээж шийджээ. Ээж мориныхоо амыг татан зогсож,

- Миний хүү, сонсч бай! Хэчнээн хүнд үед ч нөхрөө аюулд орхиод өөрийн амийг хаацайлагч бол муу хүн. Бид хоёр цааш ингэж явж хэрхэвч таарахгүй. Иймийн тулд нөхдөө цуглуулахыг оролдох хэрэгтэй гээд нүдээ анивчин ноштойгоор,

- За миний хүү одоо чи ингэ. Даваа гуяинд оч. Тэднийх Мухарын аманд байгаа. Түүнтэй очиж уулзаад намайг уулзах чухал хэрэгтэй байна гэж хэлээд ир. Би чамайг Сүрэн хөтчийнд хүлээж байя. Тэднийх захдуу нутагладаг тул хэрхэвч намайг тэнд бий гэж сэжиг авахгүй биз. Замдаа болгоомжтой яваарай! Хэрэв ямар нэгэн гай зовлон болж тэднүүс чамайг барих гэвэл чи зугтаан одож өөрийн амийг хамгаал! Баригдах аюул тулваас үг өчгийг алдаж болохгүй гээд намайг үнсэв.

Ээжийн итгэл даалгаврыг биелүүлэх гэж би морий нь унаад хурдлан давхилаа.

- Ээж минь явган үлдээд, тэртээ энгэр өөд аажуухан торолзон алхана. Миний хойноос тэр үе үе эргэн харсаар л явна. Намайг хөтөл дээр гараад эргэж хархад минь тэртээ энгэр өөд маусаар л байв. Даваа гуяинд намайг хүрэхийн даваан дээр хэсэг морьтой хүн миний урдаас угтан ирэх нь харагдав. Ажиглавал, үл таних хэдэн хүн, бас өнөөх Молом гуай байна. Молом гуайг байхад нь би үнэхээр их баярлаж түүний зүг морины хурдаар довлон очив.

- Молом гуай! гэж би түүнийг суллагдаад ийнхүү чөлөөтэй яваад нь баярлан хашгирахад тэр хажуу дахь улс уруугаа хяламхийн хараад,

- За, дүү минь хаанаас ирэв? Ээж чинь хаана байна вэ? Даваа үзэгдэв үү? гэж асуув.

- Үгүй хэмээн би хариулаад нэгэнт итгэж болох хүн байсан тул,

- Та нар бүгд суллагдаа юу? Сэргэлэн ах яасан бэ? гэж асуусанд тэр нүдээ ирмээд хэлсэн нь:

- Бурханы авралаар, би суллагдав гээд нөгөө хоёр луугаа харан:

- Энэ манай талийгч Содовын хүүхэд. Энэ хүүхдээс сайн асуувал эхийнхээ байгаа газрыг зааж өгөх биз.

- Жаал аа гэж тэдний нэг өндөрдүү хамартай нь дуудаад:

- Бид Сэргэлэнгийн бүлэг сайчуудын эгнээнд орох гэж зэргэлдээ хошуунаас ирсэн улс. Энэ Даваа одоо бүх ажлыг сэргээн эхэлж байгаа гэж дуулдах юм үнэн үү? Нөгөөтэйгүүр танай ээж ч бас гол хүн мөн дөө.

- Би мэдэхгүй гэж би хаширлаад жаахан хөмсгөө атируулж: “Энэ юун улс вэ?” гэсэн мэт тэднийг сайтар ажиглав. Молом хэлсэн нь:

- Чи эднүүсээс битгий бишүүрх. Ээж чинь хаана бий вэ? гэв. Нэгэн хэсэг ээжийнхээ хаа байгааг хэлэх үү, яахав гэж би эргэлзсэнээ, Молом гуай энд байгаа болохоор аюулгүй биз гэж бодоод,

- Сүрэн хөтчийнд бий! гэсэнд тэдний нөгөө нэг жижиг, навтгар нуруутай нь миний морийг цулбуурдаад:

- За зүйтэй. Тэгвэл чиний ээж дээр очъё. Алив, хамт явъя! гээд морио гуядав. Энэ хүмүүсийн байр байдал болоод Молом гуайн хуучныхтайгаа адилгүй зан байдлыг би нэг л сэжиглэж, айн зэвүүрхэх болов. Хэсэг яваад Молом хэлсэн нь:

- За нөхөд минь, та нар үүний ээжтэй очиж тавтай ярилц. Би тэнд очих хэрэг юу байна. Миний хэрэг дуусаа биз дээ?

- Тийм тийм, нэгэнт чиний хэрэг өнгөрөв. Бидний ажилд ийнхүү сайн тус үзүүлсний чинь төлөө чамайг сүүлд хөхүүлэн магтя гэсэнд тэр доош бөхийн ёслоод,

- Хүүхдийн дэргэд эвгүй юм ярих тусгүйг болгоогоорой. Одоо нохой Давааг барьж атгандаа хийлээ л бол та нарын хэрэг бүтлээ гэлээ.

Ингэхийн хамт тэд над уруу эргэн хараад царай нь эрс хүйтэн болж, нүд нь нохойнх шиг хилэнтэй гялалзав. Молом мориндоо ташуур өгөн давхиж одлоо. Миний дэргэд үлдсэн хоёрын нэг нь миний морины цулбуураас атгасан хэвээрээ,

- За урвасан хулгайч балчир зулбадас ээжээ бушуу зааж өг! гэхэд нь нөгөө нь:

- Давхиулаад! гэж зааварлав.

Нэг нь миний хойноос хөөн морий минь ташуурдана. Би Моломын зүг эргэн хараад, хэрхэн тэр ингэж урвасныг нь сая л мэдэж, гэнэдсэндээ болоод хоолой минь зангирав.

- Урвагч! Шившигт урвагч! гэж би амандаа шивнэв. Тэгээд анх манайд аавыг ирсэн орой Сэргэлэн ах, тэдэнтэй Моломын ирсэн, дараа нь хэлж байсан бузар хуурамч үгс, сүүлд нь ойд холоос ирлээ гэсээр ирж Сэргэлэн ахыг барьсныг дэс дараалан санаж, энэ бол анхнаасаа бузар урвагч байж шүү гэж хилэнт нударгаа зангидав.

Энэ үед нар нэгэнт жаргажээ. Хавь ойрыг үдшийн бүрий бүрхээд холын бараа тасарч байв.

Нарийн голыг гатлаад, Сүрэн гуайн зусаж байгаа дэнж болно. Би нутгийн хүн болохоор андахгүй. Тэгээд ээждээ хэрхэн дохио өгөх билээ гэж сандран “Ямар нэгэн аргаар ээждээ чимээ өгөх сөн. Тэгвэл, ээж минь мэдээд амь зулбан зугтаж чадах байгаа. Би ч яахав ” гэж бодлоо.

Айлаас саахалтын хэрийн байхад тэдний нохой шуугин ирэв. Би ээжийг сонсог! гэж байдаг чадлаараа,

- Ээж ээ, Зугтаа! Харсан зүгтээ зугтаа! Молом урвагч, Молом урвагч шүү! гэж хашгиртал хойно явсан хүн,

- Энэ чинь яадаг лүүд вэ гээд далан дээрээс барин авч доош дараад амыг минь таглахаар завдав.

- Ээж ээ, зугтаа! Молом урвагч, Молом урвасан шүү! гэж шөнийн бүрэнхийд эцсийн удаа хашгирч амжтал нүүрэн дээр минь нэгэн хүнд юм дарах шиг болоод, би ухаан алджээ.

Хилэн

Ээж миний хашгирахыг сонссон байжээ. Нохой хуцах дуун дундаас хүүгийнх нь “Молом урвагч шүү!” гэсэн дуу тодоос тод сонсогджээ. Тэр даруй ээж аргамжаатай байсан морийг зайдалж унаад харсан зүгтээ зугтаан оджээ. Хуягууд түүний зутсаныг мэдсэн ч үгүй, нохой хуцах дуун дундаас морины довтолгооныг сонссон ч үгүй. Нөмгөн дээлтэй, толгой нүцгэн гарсан миний ээж шөнөжин давхиад, өглөө үүр хаяарч байхад Моломын гадаа бууж байжээ.

“Мөнгөөр эр зоригоо худалдаж, нөхдөө нохойн аманд өгсөн чамайг би өөрийн гараар үгүй хийнэ! Эр нөхөр минь дайсанд үүний л гайгаар орж, хань нөхөд минь ч үүний л хөөгөөр олзлогдоод, эцсийн эцэст үрий минь бузар хар саварт атгуулсан чамайг өөрийн гараар үгүй хийхгүй болж гэм хэний хэн болох бол доо! хэмээн ээж бухимдан цээжинд нь өшөө хорслын хилэн бадарчээ. Тэр морио тэдний хаяанд тушаад аавын үлдээж орхисон гар бууг гартаа атган гэрт гүйн оров. Угаасаа гэртээ ганцаар суудаг тэр хуурамч дайсан орон дээрээ унтаж, амттай зүүд зүүдэлж байгаа бололтой. Ээж түүний хучлагын сэжүүрээс бариад,

- Бос! хэмээн зандрав.

Молом сэрээд гэнэт ухаан дүрсгүй орилов. Түүний өмнө бууны аймшигтай хар ам болоод үс нь сэгсийж, хилэнт нүдээр түүнийг цоо ширтсэн чиирэг эмэгтэй зогсож байв.

- Амь өршөө! гэж тэр чичирхийлсэн дуугаар уйлагнан, ээжийн хөлд сөгдөв.

- Урвагч! Урвагч аа сонс! гээд ээж:

- Чи миний нөхрийн толгойг Долойд тушаагаад, бас тэгээд зогсохгүй нөхдий минь, алаг хонгор үрий минь юунд тушаав? Энэ бүгд үнэн үү?

- Үнэн! гэж Молом уйлагнан,

- Үнэн билээ. Насан минь, үнэн билээ. Би урвагч. Би бүтэлгүй урвагч бүр дүрээрээ мөн. Намайг өршөө! Энэ ч миний аргагүй байдлаас болсон. Долой надад мөнгө өгч, “Энэ нутагт хэн гаднаас ирэв, түүнийг тагнаж мэд. Цаг төр осолтой байна. Хэрэгтэн хүнийг олбол чинь чамд их шан өгч мөнгөөр цатгана” гэсэн юм гэж тэр уйлагнан “Амий минь л өршөө” гэж гуйна.

Ээж хэлсэн нь:

- Хүний нүнжиггүй ийм цэвдэг сэтгэлтэн хаана ч одоо хэрэггүй болсон! Хэргээ өнгөрсөн хойно, битгий олон юм тооч! гээд дотроо “Үүнийг яахав?” гэж эргэлзсэнээ, “Үгүй хийх ёстой! Нөхдийнхөө өмнөөс өшөөгөө авах ёстой!” гэж эрс шийдэн,

- Миний өмнөөс, хувьсгалчдын нэрийн өмнөөс гээд гох дарж орхив. Молом үхэтхийн унажээ. Ээж гараад мориндоо мордон хуй салхи адил хурдлан алга болов.

Хар гэр битүү хүнтэй. Энд гав дөнгөтэй хүмүүс л байна.

Хэн хэн байна вэ гэж уншигч сонирхвол, өнөөх л аавын нөхөд цөмөөр байна. Гав гинжинд хүлэгдсэн, зодуур нүдүүрт бэртсэн энэ хүмүүсийг уг нь хүрээний зүг явуулах ёстой байжээ. Тэгэвч цаг төрийн үймээн дунд Долой учраа олохоо байж, өргөөн дотор тэр хий л уухичин байж, “Бөөн урвагчийг барьсны минь үнэлэх хүн энэ хорвоо дээр байна уу? Хүрээнд улаантны урвасан хулгай нар орсон гэнэ. Тэр ч яах аргагүй үнэн гэнэ билээ. Манай энд, зах хязгаар нутаг боловч тэд удахгүй ирэх чимээтэй. Хэрэв тэгэхэд хүрвэл эднүүсийг цөмийг чөлөөлөөд надад хааны шан өгөхийн оронд хар тугалга амсуулах биз. Яая даа байз, яая? Цөмийг нь өрсөж үгүй хийхээс биш” гэж бодно. Энэ үеэр нэгэн ухаан мэдрэлгүй жижигхэн хар юмыг хуяг өргөөний хаалгаар оруулж ирээд үүдэнд хаяв. Долой сэг тоншдог хэрээ шиг түүний дээрээс өнгийж үзээд,

- Үүнийг хаанаас барив? Эх нь яасан бэ? гэв. Хуяг түгдчин өгүүлэх нь:

- Эхий нь бас л алдчихлаа. Тэр байх ёстой газраа байсан атал энэ муу зулбадас орилж байж сэхээ авахуулахаар барахгүй Моломын урвагч гэдгийг ч хүртэл хашгиран хэлсэн шүү.

- Задарсан новш! хэмээн Долой дургүйцсэн байдалтай тэр хүү үрүү хараад,

- Хамаг хэргийн эзэн, энэ муу зулбадас байсныг би эртхэн мэдсэн бол доо... Амьд юм уу, наадах чинь?

- Мэдэхгүй, ноёнтоон. Эгээ л сүнс нь зайлчхаагүй байлтай билээ. Бууны бөгсөөр л толгой дундуур нэг аяархан тоншоод авсан юм. Тэгээд л чимээгүй болсон гэхэд Долой очих хүүхдийн чихнээс барьж сэгсэрч үзсэнээ,

- Энэ ч сэхэхээсээ өнгөрсөн байх аа даа. Хар гэрт аваачиж өнөөдүүлийн дэргэд хая. Итгэлт хүнээ ямар шуу болсныг тэд үзэг! Аа нэг юм саналаа. Үүнийг нэгжсэн үү? Өнөөх ардын намын бичиг хаана байна?

- Алга билээ, ноёнтоон гэж хэлээд хуяг хүүхдийг өргөж гаргав. Хар гэрийн хаалга онгойлгоод, гэрийн хаяанд өнөөх хүүхдийг хаяжээ. Хоригдогсод тэр зүг гинж юугаа харжигнуулан ойртов. Хамгийн түрүүнд хүүгийн биенийг нааш эргүүлсэн Сэргэлэн ах,

- Төрөө минь! Ээ чааваас даа, Төрөө минь! гээд хоолой нь зангиран муухай орилсонд, бүгдийн зүрх зогсчих шиг л болмоо. Энэ хүүхэд бол би байсан юм гэдгийг тайлбарлахын хэрэг юун.

Хэн байсан бэ

Долой захирагч:

- Хоригдлуудыг нөгөөдөр буудна. Хүн харахгүй шиг газар үүнийг гүйцэтгэх нь чухал. Харин энэ хэргийг хэзээ ч, хэнд ч хэлж үл болно! гэж хоёр хуягтаа дуулгаад тэднийг гарсан хойно бодсон нь:

“Бүх хэрэг ч өнгөрсөн шүү. Юутай ч байсан өнгөрсөн. Харин яаж шүү оргон зугтааж гардаг юм билээ. Ардын намыханд баригдалгүй, амь зулбавал бүх хэрэг гүйцээ” гэж бодон суутал түрүүчийн хоёр хуягийн нэг нь эргэн орж ирээд мэхэсхийн сөгдөж:

- Эзэнтээн! Молом уржигдрын цаад шөнө хүнд хорлогджээ. Ямар нэгэн зальт хүн түүнийг унтаж байхад нь алсан байна. Энэ ч яах аргагүй өнөөх урвасан хулгай нарын нэг байсан биз гэсэнд Долойн нүд орой дээрээ гарч ирээд дотор нь эвгүй болж,

- Яана гэнэ ээ? Алчихсан гэнэ ээ? гээд цээжээ даран суув.

- Одоо ч өнгөрлөө. Моломын урвасны төлөө тэгж шийтгэсэн хүмүүс маргааш юм уу, өнөө шөнө намайг шийтгэнэ. Зугтаахаас өөр мэхгүй! гээд айдас нь улам их хүрч,

- Одоо бүх хэрэг баларчээ гэж бие нь чичрэн салгалав. Энэхүү өдрийн орой, бүрэнхий хавьд гэнэт нэгэн бүлэг хүмүүс хар гэрийн зүг довтолгон ирж, хуягийг баривчлаад доторх хүмүүсийг нь чөлөөлөн гаргажээ. Эд ямар хүмүүс байсан бэ гэвэл миний ээж, Даваа ах тэргүүтэй хувьсгалчид байсан билээ. Ойд очоод гурав хоносны дараа миний бие овоо тэнхэрч, толгой хавдартай боловч босч явж чадахуйц боллоо. Аймшиггүй эрэлхэг ээжийнхээ дэргэд, анчин ах Сэргэлэнгийнхээ дэргэд, аавын нөхдийн дэргэд байх гэдэг надад жаргал байв.

- Ардын намын их цэрэг айсуу гэнэ хэмээн ээж бидэнд сонин болгож яриад,

- Дайснуудыг тэд ид шидтэй мэт түргэн ялж байна. Хойд нутаг хошуудаар шинэ журам тогтоосон нь цөм ядуу ардын эрх ашгийн төлөө гэнэ. Уриалан тунхаглах бичиг хэрэгжин биелж, тэрхүү бичгийн хойноос олон түмэн даган явж байна. Аямгаас манай хошуунд ахмад партизан нэг хүн ирэх гэнэ гэлээ. Тэр үеэс эхлэн хошууны тамгын газар хөлтэй дээрээ улам хөлтэй болж,

ноёд ихэс ундуй сундуй зугтах болов. Эдний дотор өнөөх Долой бас явна.

Сэргэлэн ах бид хоёр нэгэн өдөр түүнийг барихаар мориор хөөв. Түүнийг хүндээр шийтгэвээс зохих байсан юм. Ингэхийн тулд барин авч, ардын намынхныг ирэхлээр өгч зүйл дуусгах нь зүйтэй байсан билээ. Тэр эргэн харж, бид хоёрын хөөж явааг мэдээд, эргэж буудав. Харилцан буудалцаж байх зуураа Сэргэлэн ах хэлэх нь:

- Чи битгий бууд. Баруун жигүүрээр өмнүүр нь тосон давхи. Суманд өртөгдөж мэднэ! Би түүнийг одоохон барина гэлээ. Ахын үгээр би баруун жигүүрээр нь түүнийг тосон элдэв. Тэр хоёр харилцан буудалцсаар л байлаа. Долойгийн морь суманд оногдон годройтон унасанд тэр үсрэн босоод явган сууж ахын зүг буудсаар байна. Ах бас суманд оногджээ. Мориньхоо буруу талруу толгой нь унжив. Тэгэвч морь нь давхисаар байлаа. Би хилэгнэн хорсож, Долойн зүг морины хурдаар давхилаа. Тэр миний урдаас нэгэн удаа буудаад ахиад буудах гэсэн ч сум нь дуусчээ. Буугаа бариад миний урдаас ирлээ.

- Зогс! гэж би хашгирав. Буугаа би бэлхнээ урдаа бариад түүнийг хөдөлбөл л гохоо дарахад бэлэн байв.

- Гараа өргө! гэж би хашгирав. Тэр номхон хүлцэнгүй царайлж уйлагнан,

- Дүү минь, ахыгаа өршөө! Ахыгаа өршөө! гэсээр морио гуядан ирэв.

- Зогс! гэж хашгирав. Тэр үл зогсоно. Тэхээр би морио гуядан, урагш дөхөж,

- Хэрэв зогсохгүй бол буудлаа! гэж буугаа хараалсанд тэр шонгийн мод мэт гоохойн зогсов.

- Цаашаа хар! гэж би захирав. Миний үгээр тэр цаашаа харав.

- Чигээрээ яв! Хөдөлбөл буудна! гэсэнд тэр гуйвганан явлаа. Би түүний хойноос сажлуулж, Сэргэлэн ахын зүг харахад, түүний морь тэртээ тэнд зогсон, өвс хазална. Ах толгой нь унжсан хэвээр...

- Ахыг минь алсан байх гэхээс би тогтож байж ядна. Ах өөрөө хэлэхдээ:

- Ямар ч байсан дайсныг амьдаар олзлон барих ёстой!

гэсэн тул би энэ үгэнд захирагдан, ахын зүг дайсныг орхин явж зүрхэлсэнгүй билээ. Долойг туусаар Сэргэлэн ахын дэргэд ирлээ. Ах минь цээжээ даран, мориныхоо дэл үрүү бөхийжээ. Туйлын ядруу шивнэсэн дуугаар,

- Наадахаа туугаад яв! Би хойноос чинь дагая гэж Сэргэлэн ах хэлэв. Ингэж би Долойг ойрын айлд хүргэж, ахыгаа хүн амьтантай уулзуулсан юм. Долойг нутгийн партизан отрядын дарга Даваад тушаав. Харин Сэргэлэн ахыг нэгэн айлд хэвтүүлэв. Чухам яг л энэ үед хошууны хэргийг төвхнүүлэн, ардын төрийг тогтоохоор томилогдсон төлөөний түшмэл манайхны зүг довтолгож явлаа. Тэр түшмэл өндөр чийрэг нуруутай, эрэлхэг харитай хүн байв. Энэ хүнийг хүмүүс урьд хэзээ ч юм, магад нэг үзсэн мэт санагдана. Энэ хэн байсан бэ? гэвэл миний аав, анхны партизан Содов байсан юм.

Төгсгөл

Энэ үеэс хойш би ардын цэрэг болсон юм даа. Аавынхаа дайчин нөхдийг даган ёстой цэрэг эр болоод, хувьсгалын эсэргүү нарын эсрэг зэвсэг барин тулалдаж явлаа. Дараа нь би бүр том болсон хойноо ардын цэргийн ангид алба хааж, Халх голын тулалдаанд орсон юм. Би морьт хороонд тулалдаж явсан. Одоо өвөө нь насныхаа жаргалыг эдэлж явна. Энэ жаргалыг анхнаас нь буй болгоход “Амьд тунхаг” гэж нутгийнхандаа нэрлэгдэж явсан өвөөгийнх нь түүх гэвэл энэ байна.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.